


ТАЙЛАН 2013/2014



Independence

Quality

Impact

Хараат Бус Судалгааны Хүрээлэн IRIM

Хаяг: Монгол улс, Улаанбаатар 14201, Сүхбаатар дүүрэг,
8-р хороо, Бага тойруу, 45-30 тоот

Шуудангийн
хайрцаг: 46A/265 Улаанбаатар, Монгол

Вэб сайт: www.irim.mn

Фэйсбүүк хуудас: IRIMongolia

Утас: +976-7011-7101

АГУУЛГА

IRIM-ийн тухай

Өмнөх үг

IRIM хүний нөөц

IRIM тоогоор

2014 оны зорилтууд

Хэрэгжүүлсэн төслүүд

Хэрэгжүүлж буй төслүүд

3

4

5

6

7

8

55

ТАЙЛАН 2013/2014

ЭРХЭМ ЗОРИЛГО

Шинжлэх ухааны нарийн судалгаа, шинжилгээнд тулгуурлан үйлчлүүлэгчдээ дэлхийн жишигт нийцсэн хараат бус, үнэн бодит, найдвартай мэдээллээр хангасанаар бүс нутгийн судалгааны зах зээлд мэргэжлийн өндөр стандарт бий болгож нийгмийн судалгааны чиглэлийн тэргүүлэх төв болно.

БИДНИЙ ҮЗҮҮЛДЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

Судалгаа: Бид найдвартай аргазүйд үндэслэсэн тоон ба чанарын судалгааны төсөл боловсруулж, хэрэгжүүлж ирсэн. Олон мянган оролцогчдоос, сэдэвчилсэн олон асуудлаар найдвартай мэдээлэл муглуулж, мэдээлэлд нарийвчилсан шинжилгээ хийдэг.

Хяналт үнэлгээ: Төслүүдэд хөндлөнгийн байр сууринаас, үнэн бодитой үнэлгээ өгдөг. Хяналт үнэлгээний ажилд тохирох нөөцийг тогтоож, төлөвлөгөө ба биелэлтийн зөрүүг судалж, үр дүн, нөлөөг үнэлснээр төслийн үр дүн, үр ашгийг дээшлүүлэхэд тусалдаг.

Сургалт: Бид иргэд, олон нийт, төрийн алба, хувийн байгууллага хувь хүмүүст оролцооны янз бүрийн аргаар сургалтууд зохион байгуулж байна.

Нөлөөлөл: Бид судалгаанд тулгуурлан төрөл бүрийн чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаа төлөвлөж, хэрэгжүүлдэг. Энэ нь төрийн бодлого шийдвэрт нөлөөлөх, тухайн асуудалд олон нийтийн зүгээс өгөх ач холбогдол, ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой.

ХАМРАХ СЭДЭВ:

- Засаглал
- Нийгмийн эрүүл мэнд
- Уул уурхай, байгаль орчин
- Боловсрол
- Хөдөөгийн өрхүүд

ӨМНӨХ ҮГ



ТУЗ-ийн дарга
Г.Цогтбаатар



Гүйцэтгэх захирал
А.Долгион

Азийн бүс нутгийн эдийн засгийн өсөлт сүүлийн хоёр жилд саарсан хэдий ч дэлхийн хэмжээнд хамгийн түргэн өсөлтийг үзүүлсэн хэвээр байна.

Сонирхол татам энэ бүс нутагт орших Монгол Улсын нийгэм, эдийн засгийн төлөв байдлыг сонирхогч гадаад, дотоодын байгууллагууд нэмэгдэх болж орон нутгийн судалгааны байгууллагуудаас дэлхийн түвшинд хүрсэн гүйцэтгэлийг шаардаж байгаа энэ цаг үе нь манай байгууллагын хувьд сорилт бас боломж билээ.

2013 онд манай байгууллага судалгаа, зөвлөх үйлчилгээний 27 төсөл хэрэгжүүлсний 66 хувийг олон улсын байгууллагууд, 19 хувийг төрийн байгууллагууд, 15 хувийг хувийн хэвшлийн томоохон компаниуд захиалжээ.

Мөн 2013 оны харилцагчдын маань 60 гаруй хувь нь сүүлийн гурван жилийн турш манай байгууллагаар давтан үйлчлүүлсэн байгаа нь Хараат бус, Мэргэжлийн тодотголтой манай хамт олны ажлын үр дүн юм.

2013 он нь бидний хувьд олон улсын харицаа холбоогоо өргөжүүлсэн, судалгааны ажлын бүх шатанд чанарын хяналтын системийг нэвтрүүлсэн, ажлын байр болон техник хэрэгслийнхээ хүчин чадлыг эрс сайжруулсан, бизнесийн судалгаа,

зөвлөх үйлчилгээний чиглэлээр шинэ охин компаниа өлгийдсэн хөгжил дэвшлийн жил байсныг дуулгахад таатай байна.

Энэхүү эмхтгэлээр IRIM судалгааны хүрээлэн зөвхөн өнгөрсөн онд хийсэн ажлаа тайлагнахыг гол зорилго болгоогүй бөгөөд Монгол улсад хийгдэж буй зарим судалгааны ажлыг хураангуйлан нийтэлж түгээх энэ мэт ажил нь монголыг сонирхогч байгууллага, эрдэмтэн судлаач, бодлого боловсруулагч зэрэг олон талуудад танин мэдэхүйн ач холбогдолтой гэж үзсэн. Уншигч та энэхүү эмхтгэлд нийтлэгдсэн судалгаа, шинжилгээний ажлын бүрэн эхийг холбогдох захиалагч байгууллагуудаас албан ёсны зөвшөөрөлтэйгээр авч ашиглахыг зөвлөж байна.

Цаашид бид захиалагчид болон манай судалгаанд үргэлж дэмжлэг үзүүлж ажилладаг орон нутгийн удирдлага, албан хаагчид, судалгаанд оролцож үнэтэй мэдээлэл өгч хамтарч ажилласан иргэдийнхээ итгэлийг дааж чанартай, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн судалгаа, зөвлөх үйлчилгээг хүргэж байхын тулд хичээн ажиллах болно.

Манай байгууллагыг сонгож ажилласан, судалгааны үр дүнг энэхүү эмхтгэлд нийтлэх боломжийг олгосон харилцагч нартаа талархал илэрхийлье.

Улаанбаатар, 2014 он

IRIM ХҮНИЙ НӨӨЦ

МАНАЙ СУДЛААЧИД



Манай байгууллага судалгаа, сургалт, төсөл удирдан зохион байгуулах болон зөвлөх үйлчилгээний өндөр мэдлэг туршлагатай 25 тогтмол ажилтантай. Манай ажилчид социологи, нийгмийн ажил, нийгмийн эрүүл мэнд, улс төр, сэтгэл зүй, эдийн засаг, хууль эрх зүй, менежментийн чиглэлээр мэргэшсэн бөгөөд нийгмийн судалгааны чиглэлээр гурваас хорин жилийн ажлын туршлагатай мэргэжилтнүүдийг эгнээндээ нэгтгэсэн.

Зөвлөхүүдийн баг: Байгууллага нь шаардлагатай үед зохих үйл ажиллагаа, арга зүйг хэрэгжүүлэхэд олон улсын хэмжээнд ажилласан туршлагатай үндэсний болон гадаадын мэргэжилтэн, зөвлөхүүдийн багийг ажиллуулдаг. Тэд байгууллагад шаардлагатай гүнзгий мэдлэг туршлага, төсөл хэрэгжүүлэхэд чухалд тооцогдох инновацийг нэвтрүүлж байна. Тэд төслийн удирдагч, багийн ахлагч нарт шууд хариуцан тайлагнаж ажилладаг ба аливаа төсөл, арга хэмжээнд бодитой үр дүнг авчирдгаараа онцлог юм.

Туслах баг: Төслийн туслах ажилтнуудын дийлэнх нь IRIM-ийн хэрэгжүүлж буй төслүүд дээр гэрээлэн ажилладаг ба гэрээт ажлын онцлогоос хамааран тогтмол болон тодорхой хуваарийн дагуу ажиллаж байна. Манай байгууллага харилцагчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэдлэг, чадвар бүхий олон гэрээт судлаачдын багийг бүрдүүлсэн байна. Бид ямар ч үед судалгаа шинжилгээний төсөл дээр дэмжлэг үзүүлж ажиллах 30 орчим гэрээт судлаачидтай.

IRIM ТООГООР

НИЙТ
67
ТӨСӨЛ



2008 ОНЫ
4 сараас

2013 ОНЫ
12 сар

29

Засаглал

12

Маркетинг,
эдийн засаг

8

Боловсрол

8

Нийгмийн
эрүүл мэнд

6

Хөдөөгийн
өрх

4

Уул уурхай,
байгаль
орчин



79354
Респондент




55 Захиалагч





100 Хамтрагч

ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭН ГАЗРУУД



Улаанбаатар	52	Хөвсгөл	11	Орхон	9
Ховд	21	Архангай	10	Увс	9
Дорноговь	16	Сүхбаатар	10	Говьсүмбэр	8
Өмнөговь	16	Төв	10	Дундговь	8
Дархан-уул	14	Хэнтий	10	Сэлэнгэ	6
Өвөрхангай	14	Баян-Өлгий	9	Булган	4
Баянхонгор	11	Дорнод	9	БНХАУ Эрээн хот	2
Говь-алтай	11	Завхан	9	Давхардсан тоо 279	



Бидний ёс зүйн болон мэргэжлийн зарчим



Олон улсын социологийн холбоо (ISA)-ийн гишүүний хувьд бид тус холбооны Гүйцэтгэх зөвлөлөөс баталсан Ёс зүйн дүрмийг хатуу баримтлан ажилладаг.



Манай хүрээлэнд Нийгмийн хариуцлагын Азийн сүлжээний Гүйцэтгэх хорооны гишүүн байгууллага. Иймээс бид нийгмийн хариуцлагатай үйл ажиллагааг дэмжин ажиллахыг зорьдог.



ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ



ASIAN DEVELOPMENT BANK



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛЭГЧИЙН
ТАМГЫН ГАЗАР



**Олон улсын
стандартыг
мөрдөх**

**Дэвшилтэт
техник,
технологи
ашиглах**

**Хүний
нөөцийн
чадавхийг
бэхжүүлэх**

2014 ОНЫ IRIM-ИЙН ГОЛ ЗОРИЛТУУД

Ирэх онд IRIM судалгааны хүрээлэн харилцагчдынхаа хүрээг тэлж, тэдний сэтгэл ханамжийг дээшлүүлэхийн тулд дараах үйл ажиллагаанд анхаарлаа хандуулах болно.

- Судалгааныхаа чанарын хүрсэн түвшинг улам ахиулахын төлөө хүчин чармайлт гаргана. Мөн төслүүдийн чанарын хяналт хариуцсан нэгжийг тусад нь байгуулж ажиллана.
- Судалгааны ажлаа шуурхай, зардал багатай зохион байгуулахын тулд мэдээллийн технологийн орчин үеийн шийдлүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг эрчимтэй үргэлжлүүлнэ. Өнгөрсөн хугацаанд бид хэд хэдэн судалгааны мэдээллийг таблет, компьютер, мобайл програм, GPS систем ашиглан цуглуулж байсан. Одоо боломжит бүх төрлийн судалгаанд үүнийг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Байгууллагынхаа мэдээллийн санг боловсронгуй болгох, тоон болон чанарын шинжилгээний орчин үеийн хүчирхэг програмуудыг судалгаа шинжилгээнд ашиглах бодлогоо үргэлжлүүлнэ.
- Байгууллагынхаа давуу тал болох судалгааны арга зүй, аналитик шинжилгээний түвшинг бататгаж, улам ахиулах зорилгоор судлаачдынхаа олон улсын тавцанд эрдэм шинжилгээний бүтээлээ хэлэлцүүлэх, эрдмийн зэрэг хамгаалах, судлаачдаа академик болон арга зүйн сургалтад хамруулахад өндөр ач холбогдол өгнө. Байгууллагынхаа судлаачдын төдийгүй түнш харилцагчдынхаа ажилтнуудад судалгааны арга зүй, судалгааны програм хангамжийн мэдлэг, чадвар олгох сургалтыг тогтмол зохион байгуулна.

2014 онд IRIM судалгааны хүрээлэн нь олон улсад танигдсан, бүс нутгийн хэмжээнд судалгаа, шинжилгээ явуулдаг, иргэдийн амьдралд хэрэгцээтэй бодлого, шийдвэр гарахад гол үүрэг гүйцэтгэсэн шилдэг байгууллага болохын төлөө хичээж ажиллах болно.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД



ЗАСАГЛАЛ ДАХЬ ХҮҮХДИЙН ОРОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ




Захиалагч: Японы Хүүхдийг Ивээх Сан

Судалгааны зорилго: Суурь судалгааны зорилго нь орон нутгийн засаглалын бүхий л түвшин дэх хүүхдийн оролцооны өнөөгийн нөхцөл байдлыг тодруулж, хүүхдийн оролцоог хангахад тулгамдаж буй асуудлууд болон цаашид хүүхдийн оролцооны цар хүрээ, арга хэлбэрийг өргөжүүлэх хэрэгцээ, боломжийг тодорхойлоход оршино.

Энэ хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно. Үүнд:

1. Хүүхдийн оролцооны өнөөгийн нөхцөл байдлыг гэр бүл, сургууль, орон нутгийн түвшинд судалж тодорхойлох,
2. Хороо, дүүрэг, нийслэлийн түвшинд төсөвлөлт, төлөвлөлт, хэрэгжилтийн хяналт зэрэг үе шат тус бүрт хүүхдийн оролцооны байдал ямар түвшинд байгааг дүрслэх
3. Хүүхдийн оролцоонд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг тодорхойлох
4. Орон нутгийн түвшинд хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх бодлогын агуулга, түүнийг хэрэгжүүлэх арга зам, боломжуудыг нээх, зөвлөмж боловсруулах

Үндсэн мэдээлэл



Судалгааны дизайн, арга зүй:

Суурь судалгаанд тоон ба чанарын судалгааны аргуудыг хослуулан ашигласан. Үүнд асуулга, ганцаарчилсан ярилцлага, баримт бичиг судлах, фокус бүлгийн ярилцлагын аргууд багтаж байна.



2012 ОНЫ 10 сараас **2013** ОНЫ 1 сар



324 ЕБС-ийн сурагчид **98** Эцэг эх



71 Ганцаарчилсан Ярилцлага




6 Фокус бүлгийн Ярилцлага



59 Баримт бичгийн судалгаа

Судалгааны гол үр дүн


1: Хүүхдүүдийн дундаж оролцох эрхийн талаарх мэдээллийн түвшин



Нийт судалгаанд хамрагдагсдын 56.9 хувь нь хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээллийг бага зэрэг авч байсан гэдэг хариулт өгч байна.

Судалгаанд хамрагдсан зорилтот бүлгийн хүүхдүүд оролцооны талаарх мэдээллээр тун хомс байсан юм. Дүнг 3 - аас харна уу.


2: Зорилтот бүлгүүдийн хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээллийн түвшин



Хүүхдийн оролцох эрхийн талаарх мэдээллийг, бүртгэлгүй хүүхдүүдийн 85.7 хувь нь, сургууль завсардсан хүүхдүүдийн 73.7 хувь нь тус тус сонсож байгаагүй гэж хариулсан байна.


Зорилтот бүлгийн хүүхдүүдийн ихэнх нь хүүхдийн оролцох эрхийн ойлголт энгийн ЕБС-д суралцдаг хүүхдүүдтэй ойролцоо түвшинд байна. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 62.5 хувь нь бага зэргийн ойлголттой байгаа нь бусад зорилтот бүлгээс харьцангуй доогуур үзүүлэлт юм. Хараа хяналтгүй хүүхдүүдийн 68.8 хувь нь, хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн 62.5 хувь нь хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголт сайн байгаа нь доорх дүрсээс харагдаж байна.

3: Зорилтот бүлгийн хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголт



Хүүхдийн оролцооны түвшинг тодорхойлохын тулд бид хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан асуулгыг бэлтгэх хэрэгтэй болсон. Рожер хартын оролцооны шатлалын аргыг ашиглан, 8-11 настай болон 12-18 настай хүүхдүүдийн гэр бүл, сургууль, хорооны түвшин дэх оролцоог сайн, дунд, муу гэсэн үнэлгээгээр үнэлүүлээ. Энэ аргачлалын дагуу хүүхдийн оролцооны өнөөгийн түвшинг тодруулахад хүүхдүүд сургууль, хороо гэхээсээ илүүтэй гэр бүлийн шийдвэр гаргалтад идэвхтэй оролцдог байна. Нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 21.6 хувь нь гэр бүлийн шийдвэр гаргалтад сайн оролцоотой гэж хариулсан байна. Энэ үзүүлэлт нь сургуулийн түвшинтэй харьцуулахад 9 пунктээр илүү, хорооны түвшинтэй харьцуулахад 17.3 пунктээр илүү байгаа нь харагдаж байна. Хэдийгээр бид нийт судалгаанд хамрагдагсдын 45.3 хувь нь гэр бүлийн шийдвэр гаргах түвшинд оролцохгүй байна гэж дүгнэж болох ч сургууль болон хорооны түвшинтэй харьцуулбал оролцоо сайтай байгааг харж болно.

4: Хүүхдийн оролцооны өнөөгийн түвшин



Судалгааны гол дүгнэлт

- Хүүхдүүдийн оролцооны талаарх мэдээлэл хомс байна.
- Хүүхдүүд насанд хүрэгчидтэй хамтран шийдвэр гаргах хүсэлтэй байна.
- Гэр бүл, олон нийтийн дунд хүүхдийн оролцооны талаарх мэдлэг бага байна.
- Зорилтод бүлгийн хүүхдүүд болон бага насны хүүхдүүдийн гэр бүлийн шийдвэр гаргалтад оролцох оролцоо бага байна.
- Сургуулийн түвшинд үйл ажиллагааны төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилтийн хяналтад хүүхдийн оролцоо бараг байхгүй байна.
- Дүүргийн түвшинд хүүхдийн оролцоог хангахад чиглэгдсэн ажлууд дутмаг байна.
- Шийдвэр гаргах түвшинд ажиллаж буй удирдлагууд хүүхдийн оролцох эрхийн талаарх ойлголт харилцан адилгүй байна.
- Хорооны үйл ажиллагаанд хүүхдийн оролцоо байхгүй байна
- Хорооны үйл ажиллагааны талаарх хүүхдүүдэд чиглэсэн мэдээлэл алга байна.
- Орон нутгийн шийдвэр гаргах түвшинд хүүхдийн эрх ашигтай холбоотой аливаа төлөвлөлтөд хүүхдүүд үзэл бодлоо илэрхийлж, нийгмийн амьдралд оролцох эрхээ эдлэх боломж байхгүй байна.
- Нийслэл болон дүүргийн түвшний төлөвлөлтөд хүүхдийн оролцох эрхийг хангахад чиглэсэн ажил маш бага хувийг эзлэж байна.
- Нийслэлийн түвшинд 2 байгууллага хүүхдийн оролцох эрхийг хангах чиглэлээр ажил төлөвлөөгүй байв.
- Нийслэлийн түвшинд төсөвлөлт хийхэд хүүхдийн шууд оролцоо байхгүй төдийгүй тэдгээрийн төлөөлөл, хариуцсан мэргэжилтэн ч оролцох боломжгүй, оролцоог хангадаг зохицуулалт механизм бүрдээгүй байна.
- Орон нутгийн төсөвт “хүүхдийн” гэсэн тодотголтой зардал туссан эсэхийг мэдэх, үнэлэх боломжгүй байна.
- Нийслэлийн төсөвт хүүхдийн оролцох эрхийг хангах ажилд төсөвлөгдсөн зардал огт байхгүй байна.
- Нийслэлийн ИТХ-аас сүүлийн нэг жилийн хугацаанд гаргасан тогтоол, шийдвэрийн 6.17 хувь нь л хүүхдийн эрх ашигт шууд нөлөөлөх шийдвэр байв.
- Нийслэлийн хэмжээнд хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдэд хүүхдийн оролцох эрхийг хангах ажил тусгагдаагүй байна.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗАР



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



The Asia Foundation

“ОРОН НУТАГТ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ” ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГАА



Захиалагч: АНУ-ын Азийн сан, Швейцарийн хөгжлийн агентлаг


Хамтрагч: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар

Судалгааны зорилго: Орон нутгийн түвшинд иргэдийн оролцоог дэмжих (цаашид FOCE) төслийн суурь судалгаа нь орон нутгийн засаглалын талаарх иргэдийн мэдлэг, ойлголт, сэтгэл ханамжийг үнэлж, FOCE хөтөлбөрийн үр нөлөөг үнэлэх суурь мэдээллээр хангах зорилготой.

Судалгааны зорилт: Судалгаанд дараах зорилтуудыг дэвшүүлсэн.

1. Хөтөлбөр хэрэгжиж буй орон нутгийн засаглалын талаарх иргэдийн мэдлэгийн түвшинг хэмжих;
2. Нутгийн захиргаа, иргэний нийгэм болон ТББ-уудад хандсан, хамтарч ажилласан, мэдээлэл авсан байдлыг үнэлэх замаар иргэдийн оролцооны түвшинг тодорхойлох;
3. Нутгийн захиргааны шийдвэрт иргэд хэр зэрэг сэтгэл ханамжтай байгааг үнэлэх;
4. FOCE хөтөлбөрийн хяналт үнэлгээний шалгуур үзүүлэлттэй холбоотой мэдээлэл цуглуулах;

Үндсэн мэдээлэл



Хамрах хүрээ

Судалгаанд Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 8 дугаар хороо, Төв аймгийн Зуунмод сум, Ховд аймгийн Жаргалант сум, Дундговь аймгийн Дэлгэрцогт сум, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум, Архангай аймгийн Цахир сум хамрагдсан бол хяналтын бүлгээр Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо, Дундговь аймгийн Говь-Угтаал сумдыг сонгон авсан.

Судалгааны дизайн, арга зүй

Төрийн захиргааны албан хаагчид болон, ИНБ-ын удирдлагуудтай хагас бүтэцчилэгдсэн ярилцлага хийж, иргэдээс урьдчилан бэлтгэсэн асуулга анкетын аргаар судалгаа авахын зэрэгцээ баримт бичгийн судалгааны аргаар мэдээлэл цуглуулсан.



2013 ОНЫ
1 сараас

2013 ОНЫ
3 сар



554 Зорилтот
бүлгийн иргэд

171 Хяналтын
бүлгийн иргэд



43 Ганцаарчилсан
Ярилцлага




48 Баримт бичгийн
судалгаа

Судалгааны гол үр дүн


Иргэд дараах хуулиудын талаар төдийлөн мэдээлэл авч амжаагүй байна. Судалгаанд хамрагдагсдын 14% нь төсвийн тухай хууль, 9,5% нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуультай танилцсан гэж хариулсан байна. Дүрс 1-ээс хариултууд бүс нутгаар хэр ялгаатай байгааг харж болно.

1. Төсвийн ба мэдээллийн тухай хуулиудтай танилцсан оролцогчид (%)




Нийт судалгаанд хамрагдагсдаас орон нутгийн хууль, тогтоомжийн талаарх мэдээллийг хаанаас авдаг тухайд хэрхэн хариулсныг дүрс 2-т нэгтгэн харуулав.

2. Орон нутгийн хууль, тогтоомжийн тухай мэдээлэл авдаг эх сурвалжууд



Орон нутгийн төрийн байгууллагын үйл ажиллагаан дахь иргэдийн оролцооны талаарх иргэдийн ойлголтыг тодруулав. Орон нутгийн шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог хангахад нутгийн захиргааны дэмжлэг, санаачлага, ТББ болон ИНБ-уудын талаарх ойлголт, иргэдийн хурлын талаарх ойлголт, хурал иргэдэд хэр нээлттэй байгаа талаар доорх дүрс 3-т үзүүлж байна.

3 Иргэдийн санал нийлж буй ойлголтууд (%)




Судалгаанд хамрагдсан иргэдээс өргөдөл гомдлыг хэнд хандаж гаргадаг талаар тодруулав. Орон нутгийн иргэд санал хүсэлтээ ихэвчлэн тухайн асуудлыг хариуцсан холбогдох албан хаагч мөн сум, дүүрэг, баг, хорооны засаг даргад хандан гаргаж байна. Дүрс 4-т үзүүлснээр маш цөөн иргэн шууд Улсын их хурлын гишүүнд ханддаг байна.

4. Орон нутгийн иргэд санал хүсэлтээ хэнд хандан гаргаж байна вэ? (хувиар)



5. Иргэдийн санал хүсэлтэнд орон нутгийн захиргаа хариу өгсөн хугацаа (хувиар)



Судалгааны гол дүгнэлт

ИРГЭДИЙН МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ

- 1. Орон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, чиг үүргийн талаарх иргэдийн мэдлэг бага байна.** Судалгаа явуулсан бүх орон нутагт иргэдийн мэдлэг жигд муу байна. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн мэдлэг эрэгтэйчүүдийнхээс ялимгүй бага байна. Мөн боловсролын түвшин доошлох тусам энэ талаарх иргэдийн мэдлэг буурч байв.
- 2. Мэдээлэл огт авдаггүй иргэд олон байна.** Иргэдийн оролцоог хангахад чиглэсэн хууль тогтоомжийн талаар долоон хүн тутмын нэг нь л мэдээлэл авч байна. Тэр дундаа ажилгүй болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд мэдээлэл хамгийн бага авч байна.
- 3. Орон нутгийн захиргаа иргэдэд үйл ажиллагаагаа тайлагнахгүй байна.** Ялангуяа мэдээллийн эрх чөлөөний хуулийн дагуу төсөв санхүүгийн тайланг иргэдэд нээлттэй хүргэж чадахгүй байна. Мөн Улаанбаатар хотын иргэд өөрийн орон нутгийн захиргааг үйл ажиллагаа, төсөв санхүүгээ тайлагнадаггүй гэж үзэж байна.
- 4. Иргэдийн мэдээлэл авах арга зам хязгаарлагдмал байна.** Судалгаанд хамрагдсан иргэдийн бараг тал хувь нь телевизээр хууль тогтоомж, орон нутгийн захиргааны байгууллагын талаарх мэдээллийг авдаг гэж хариулсан байна. Одоогийн байдлаар орон нутагт мэдээлэл хүргэхэд хамгийн их ашиглаж буй арга зам болох хурал цуглаанд ихэвчлэн төрийн байгууллагын албан хаагчид, малчид, тэтгэвэрийн хөгшид ямар нэг хэмжээгээр хамрагдаж, бусад бүлгийнхэн орхигдож байна.

ИРГЭДИЙН ОРОЛЦОО

- 1. Судалгаанд оролцогчдын талаас дээш хувь нь иргэдийн хуралд оролцдоггүй байна.** Ийнхүү оролцохгүй байгаа шалтгааныг тодруулахад ихэнх иргэд завгүй болон сонирхоогүй гэж хариулсан бол мөн тооны иргэд хурлын талаарх мэдээллийг авч чаддаггүй гэж хариулсан байна. Тиймээс тухайн орон нутгийн иргэдэд хурлын талаарх зар мэдээ хангалттай хүрч чадахгүй байна гэж дүгнэж болно.
- 2. Өөрийн орон нутгийн захиргааг, иргэдийн оролцоог хангаж тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн шийдвэр гаргадаг гэдэгтэй иргэд санал нийлэхгүй байна.** Дунджаар судалгаанд хамрагдсдын 50 гаруй хувь нь орон нутгийн захиргаанаас иргэдийн оролцоог дэмжиж тэдний хэрэгцээ шаардлагыг сонсдоггүй гэж

үзэж байна. Мөн тухайн орон нутгийн ИНБ, ТББ-ыг өөрсдийх нь эрх ашиг, сонирхлыг илэрхийлж чаддаггүй гэж үзжээ.

- 3. Иргэд өөрийн орон нутагт тулгамдаж буй асуудлыг өөрсдийх нь оролцоотой шийдэхийг хүсэж байна.** Судалгаанд хамрагдсан орон нутаг тус бүр өөр өөр тулгамдсан асуудалтай байна. Иргэд орон нутгийн захиргаанаас тухайн тулгамдсан асуудлыг шийдэхдээ өөрсдийх нь санаа бодлыг сонсож хамтдаа шийдвэрлэж байхыг хүсч байна.

ХАРИЛЦАН СУРАЛЦАХ

- 1. Иргэд болон орон нутгийн захиргаа бусад сум, орон нутагт болж буй иргэдийн оролцоог хангасан сайн туршлагын талаар мэдээлэлгүй байна.** Иргэдийн оролцоог хангаж шийдвэр гаргаж буй сайн туршлагын талаар ихэнхи иргэд, албан хаагчид мэдээлэл авахгүй байна. Цөөн тооны мэдээлэл авсан иргэд зөвхөн телевизээр л үзсэн төдий байна.
- 2. Бусад орон нутгийн сайн туршлагыг өөрийн орон нутагтаа хэрхэн хэрэгжүүлэх талаар ойлголт муу байна.** Ялангуяа орон нутгийн удирдлагууд аливаа сайн туршлагын талаар иргэдтэйгээ адил мэдээлэл авсан төдий л байна. Тиймээс тухайн туршлагыг хэрхэн орон нутагтаа хэрэгжүүлэх талаар нэмэлт ойлголт байхгүй, арга зүй дутмаг зэрэг бэрхшээлүүд гарч байна.

ИРГЭДИЙН САНАЛ, ХҮСЭЛТ

- 1. Иргэдээс орон нутгийн захиргааны байгууллагад гаргаж байгаа санал хүсэлтийн ихэнх хувийг тэр дор нь шийдвэрлэх боломжгүй асуудлууд эзэлж байна.** Иргэд орон нутгийн захиргааны байгууллагад гэр авах, сургалтын төлбөр, тэтгэвэр тэтгэмжид хамруулах зэрэг асуудлаар хандаж байна. Уг асуудлуудыг орон нутгийн захиргаа шууд шийдвэрлэж өгөх эрх мэдэл дутмаг, хөрөнгө санхүү хүрэлцээгүй байдаг тул ихэвчлэн холбогдох дээд шатны байгууллага руу уламжлан өгдөг байна.
- 2. Орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд төсөв санхүүгийн бэрхшээл тулгарч байна.** Иргэд болон тухайн орон нутгийн захиргаанаас орон нутагтаа тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэхэд хамгийн түрүүнд хөрөнгө санхүүгийн бэрхшээл тулгардаг гэж хариулжээ.




Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



“ЗАСАГЛАЛЫГ ДЭМЖИХ, ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ” ХӨТӨЛБӨРИЙН 4-Р БҮРЭЛДЭХҮҮН “НЭГ ЦОНХНЫ ҮЙЛЧИЛГЭЭ” ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГАА




Захиалагч: Хүний Аюулгүй Байдлын Судалгааны Төв, ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ

Судалгааны зорилго: Төслийн үр дүн болон нөлөөллийг үнэлэх, НЦҮ-г чанаржуулах ба үр ашигтай болгоход шаардагдах хүрэлцээтэй нөөцийг тодорхойлж, үйл ажиллагаа болон ажлын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, төслийн багт туслалцаа үзүүлэхэд оршино. Судалгааны ажил суурь болон хяналт-шинжилгээ, үнэлгээний судалгаа гэсэн хоёр үе шаттай хэрэгжинэ.

Судалгааны зорилт:

1. 2007-2011 онд байгуулагдсан НЦҮ болон шинээр байгуулагдаж буй НЦҮ-ээс үйлчилгээ авч буй иргэдийн сэтгэл ханамжийг үнэлэх
2. НЦҮ-ээр үзүүлж байгаа төрийн үйлчилгээг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх зорилгоор бодлого болон хуулийн хүрээнд шаардагдах дэмжлэгийг тодорхойлох
3. НЦҮ-ний байр, танхим, тоног төхөөрөмж, тавилга зэрэг ажлын орчин нөхцөл байдлын талаар үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагаанууд хийгдсэн.

Үндсэн мэдээлэл



Судалгааны дизайн, арга зүй:

Энэхүү судалгаа нь ШХА-аас хэрэгжүүлж буй “Нэг Цонхны Үйлчилгээ” төслийн суурь судалгаа юм. НЦҮ-ний үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэж, төсөлд хамрагдах хүн ам өсөх ч дараагийн шатны судалгаануудад түүврийн хэмжээ өөрчлөгдөхгүй. Энэ нь түүврийн өөрчлөлтөөс хамаарах нөлөө гаргахгүй байх давуу талтай.

Түүврийн бүтэц

Судалгааны мэдээллийг анкет асуулга, фокус бүлгийн ярилцлагын аргаар цуглуулсан. Нийт 28 НЦҮ-ний цэгээс 840 үйлчлүүлэгч болон НЦҮ-ний 140 ажилтнаас асуулга бөглүүлсэн бөгөөд үйлчлүүлэгчдийг хамруулан 14 фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулсан юм. НЦҮ-ний цэг тус бүрт орчин нөхцөлийн талаарх ажиглалтын хуудсыг хөтөлж үр дүнг судалгааны тайланд багтаасан.



2013 ОНЫ
4 сараас

2013 ОНЫ
6 сар



840 Үйлчлүүлэгч

140 Нэг цонхны
үйлчилгээний ажилтан




14 Фокус бүлгийн
Ярилцлага



28 Ажиглалт

Судалгааны гол үр дүн

1. НЦҮ-ээр үйлчлүүлэгчдийн хандсан, асуудлын шийдвэрлэлт



Иргэдийн 55.6 хувь буюу олонхи нь хандсан асуудлаа бүрэн шийдвэрлүүлж чаддаг гэж хариулсан байна. Иймээс үлдэх 44,4 хувь нь асуудлаа ямар нэг байдлаар дутуу шийдүүлдэг, эсвэл огт шийдүүлж чаддаггүй буцдаг ажээ. Асуудлаа шийдвэрлүүлж чадаагүй буцсан иргэдийг хамгийн сүүлд авсан үйлчилгээгээр нь ангилж үзэхэд иргэний бүртгэл (22.8%), хөдөлмөр нийгмийн халамж (20.9%), нийгмийн даатгал (17.2%) -н үйлчилгээг авсан иргэд хамгийн өндөр хувийг эзэлж байна.

НЦҮ-ний ажилтнууд болон НЦҮ-ээр үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг тодорхой үзүүлэлтүүдээр 1-5 оноогоор хэмжсэн. (1-Маш муу, 2- Муу, 3-Дунд, 4-Сайн, 5-Маш сайн) Ажилтнууд болон үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг доорх хүснэгтэд үзүүлээ.

2. Үйлчлүүлэгчдийн зүгээс НЦҮ-нд өгөх сэтгэл ханамжийн үнэлгээ, дундаж

Үзүүлэлтүүд	Ажилтнуудын харилцааны соёл	Үйлчилгээний чанар	Үйлчилгээний орчин	Нэгдсэн үзүүлэлт
Үйлчлүүлэгчдийн өгөх үнэлгээ	3.8	3.62	3.91	3.78

Үйлчлүүлэгчид НЦҮ-д харьцангуй сэтгэл ханамжтай байна. Үйлчилгээний орчинд хамгийн өндөр үнэлгээ өгч байгаа бол үйлчилгээний чанарт бага үнэлгээ өгч байна. Аймгаар нь харьцуулан үзвэл Увс, Сүхбаатар, Төв аймгийн Баянчандмань сумдад үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж

өндөр, Говь-Алтай, Дархан, Улаанбаатарын Сонгинохайрхан дүүргийн үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж бага байна. Хөдөөгийн иргэдийн сэтгэл ханамж хотын иргэдийнхээс ялимгүй өндөр байгаа нь ажиглагдаж байсан.

3. НЦҮ-ний ажилтнуудын зүгээс НЦҮ-ний ажлын нөхцөл байдалд өгөх сэтгэл ханамжийн үнэлгээ

Үзүүлэлтүүд	Ажлын орчин	Удирдлага, зохион байгуулалт	Цалин, урамшуулал	Мэргэжлийн ур чадварт чиглэсэн үйл ажиллагаа	Орчны нэгдсэн үзүүлэлт
Ажилтнуудын өгөх үнэлгээ	3.7	3.9	3.5	3.4	3.6

НЦҮ-ий ажилтнуудын сэтгэл ханамж ч харьцангуй сайн байлаа. НЦҮ-ний удирдлага, зохион байгуулалтад илүү сэтгэл ханамжтай байгаа бол цалин урамшуулал, мэргэжил, ур чадвараа дээшлүүлэхэд үзүүлэх дэмжлэгт харьцангуй сэтгэл дундуур явдаг ажээ. Байршлаар нь харьцуулж үзвэл Дундговь аймгийн Эрдэнэдалай сум, Увс аймгийн ажилтнуудын сэтгэл ханамж харьцангуй өндөр, Төв, Хэнтий аймгийн ажилтнуудын харьцангуй бага байна. НЦҮ-ий ажилтнууд ба үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж хоорондоо тодорхой эерэг хамааралтай байна.

4. Ажилтнуудын хэрэгцээний үнэлэмж

Чухалчилж буй дундаж үзүүлэлт	Дундаж
Ажлын орчин нөхцөл	4.56
Удирдлага, зохион байгуулалт	4.45
Цалин, урамшуулал, ажлын ачаалал	4.43
Цаашид өсөж дэвших боломж	4.21

НЦҮ-ний ажилтнуудын хэрэгцээ шаардлагыг НЦҮ-ний удирдлага зохион байгуулалт, ажлын орчин нөхцөл, цалин урамшуулал ба ажлын ачаалал, цаашид өсч дэвших боломж гэсэн дөрвөн бүлэг асуудлаар тодруулсан. Эдгээр асуудал бүгд чухалд тооцогдож байгаа боловч ажилтнууд ажлын орчин нөхцөлийг илүү чухалчилж байна.

Судалгааны гол дүгнэлт



НЦҮ-ий ажилчид ба үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж хоорондоо тодорхой эерэг хамааралтай байна ($r=0.386$ ба $t=2.12$). Өөрөөр хэлбэл, тухайн НЦҮ-ий орчин, зохион байгуулалт сайн байх тусам үйлчилж байгаа, үйлчлүүлж байгаа аль аль талын сэтгэл хангалуун байгаа нь харагдаж байна.

НЦҮ-ий ажилтнуудын зан харьцаа, үр чадварт өгсөн хэрэглэгчдийн үнэлгээг дунджилж үзэхэд 5 онооноос 3,88 оноо авахаар байна. Энэ нь хангалттай сайн үзүүлэлт биш бөгөөд үүний шалтгаан нь тухайн сумын НЦҮ-ий ажилтан нь эрхэлж буй ажилдаа сэтгэл хангалуун бус байдгаас болж үйлчлүүлэгчидтэй харилцах харилцаандаа алдаа гаргадагтай холбоотой

байж болно. Гэвч үүнийг гүнзгийрүүлэн шалгахад, үйлчлүүлэгчид НЦҮ-ний ажилтнуудын харилцааны соёлд өгсөн дундаж үнэлгээ ба ажиллагсдын сэтгэл хангалуун байдлын дундаж үнэлгээний хооронд мэдэгдэхүйц хамаарал ажиглагдсангүй ($r=0.30$, $t=1.62$). Өөрөөр хэлбэл, НЦҮ-ий ажилтан ажилдаа сэтгэл хангалуун байдаг эсэх нь тэдний зан харьцаанд төдийлөн нөлөөлдөггүй гэж үзэж болохоор байна. Харин ажилтан ажиллаж буй НЦҮ-ий удирдлага зохион байгуулалтын талаар өгсөн үнэлгээ ба хэрэглэгчид тухайн НЦҮ-ний чанарт өгсөн үнэлгээ хоорондоо мэдэгдэхүйц эерэг хамааралтай ($r=0.45$, $t=2.59$) байна.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗАР



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC

Швейцарийн хөгжлийн агентлаг

“ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИАР ЗОХИЦУУЛСАН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХЭРЭГЖИЛТ БОЛОН ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ҮНЭЛГЭЭ” КЕЙС СУДАЛГАА



Захиалагч: ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ


Хамтрагч: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар

Судалгааны зорилго: Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх явцад төв засгийн газар болон орон нутгийн түвшинд гарч буй бодлого, шийдвэрүүдийн үр нөлөө болон үр ашигтай байдлыг сайжруулахад шаардлагатай мэдээллийг боловсруулахад оршино.

Судалгааны зорилт:

1. Төсвийн тухай хуулиар зохицуулсан орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилт болон түүнд оролцох иргэдийн оролцоог үнэлэх;
2. Кейс судалгаанаас гарсан үр дүнг танилцуулах.

Үндсэн мэдээлэл



Хамрах хүрээ

4 бүсийн төлөөлөл болох Архангай аймгийн Өгийнуур сум, Дундговь аймгийн Луус сум, Хөвсгөл аймгийн Ханх сум, Говь Алтай аймгийн Тайшир сум, Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Сүхбаатар аймгийн Баруун-Урт сум мөн Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 23 дугаар хороо, Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо

Судалгааны дизайн, арга зүй:

Олон кейст судалгааны арга юм. Энэ судалгааны арга нь “яаж”, “яагаад” гэсэн асуултуудад хариулт авах зорилготой бөгөөд бодит нөхцөл байдлыг илрүүлнэ.

Үнэлгээ нь сонгогдсон 8 талбарын төсвийн тухай хуулиар зохицуулагдсан ОНХС-ийн хэрэгжилт болон түүнд оролцох иргэдийн оролцооны талаар судалж дэлгэрэнгүй мэдээллийг гаргасан. Тиймээс кейс тус бүрийн онцлог талыг тодруулан, зарим ерөнхий үзүүлэлтүүдийн хүрээнд кейсүүдийг харьцуулах болно. Энэхүү үнэлгээний судалгаанд ганцаарчилсан ярилцлага, кейс судалгаа, ажиглалт, орон нутгийн баримт бичиг, статистик тоо баримтад баримт бичгийн шинжилгээ хийх зэрэг чанарын судалгааны аргуудыг ашиглав.



2013 ОНЫ
8 сараас

2013 ОНЫ
10 сар



240 Иргэн



55 Ганцаарчилсан
Ярилцлага



47 Баримт бичгийн
судалгаа



1 Ажиглалт

Судалгааны гол үр дүн

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, I ДҮГЭЭР ХОРОО (жишээ)

1. ОНХС-ийн мэдлэг ойлголт

Мэдээлэл хүргэж буй арга зам

Судалгаанд хамрагдсан орон нутгийн удирдлагуудаас ОНХС-ийн талаарх хэлэлцүүлэг болох тухай мэдээллийг хэрхэн хүргэж байгааг тодруулсан юм. Энэ талаар хорооны удирдлагууд дүүргийн албан хаагчдаас илүү мэдээлэлтэй байсан. Хорооны иргэдэд ОНХС-ийн талаарх хэлэлцүүлэг болох тухай мэдээллийг дараах аргуудаар хүргэж байна.

1. Иргэдэд мэдээлэл түгээж буй хэлбэр



Мэдээлэл авч буй арга зам

Судалгаанд оролцсон иргэдээс та төсвийн тухай хууль болон ОНХС-ийн талаарх мэдээллийг хамгийн сүүлд хаанаас авсныг тодруулахад нийт 30 иргэний 21 нь энэ талаар мэдээлэл аваагүй гэж хариулсан байна.

2. Иргэд мэдээлэл авсан эх сурвалж /%/



Харин мэдээлэл авсан иргэдийн хувьд 4 иргэн телевизээс, 4 иргэн хурал цуглаан дээрээс, 1 иргэн интернэтээс авсан гэж хариулжээ.

Иргэдийн мэдлэг ойлголт


Судалгаанд хамрагдсан 1 дүгээр хорооны 30 иргэнээс төсвийн тухай хууль болон ОНХС-д хуваарилагдсан мөнгөний талаар мэддэг эсхийг тодруулсан юм. Тэдний 8 нь төсвийн тухай хуулийн талаар мэднэ, 3 нь ОНХС-д хэдэн төгрөг хуваарилагдсан талаар мэднэ гэж хариулжээ.

3. ОНХС-ийн талаарх иргэдийн мэдлэг ойлголт /тоо/



Судалгаанд хамрагдсан иргэдээс ОНХС-ийн төсөл, хөтөлбөрийг тодорхойлоход өөрсдийгөө ямар эрх үүрэгтэй оролцоно гэж бодож байгаа талаар тодруулсан юм.

4. ОНХС-ийн төлөвлөх шатанд иргэдийн оролцох эрх үүрэг /%/



Уг асуултад хариулсан нийт 30 иргэний 17 нь буюу 56,7 хувь нь ОНХС-ийн төлөвлөх үе шатанд оролцож саналаа хэлэх эрхтэй гэж хариулсан бол 1 иргэн надад оролцох эрх байхгүй гэж хариулжээ.

2. ОНХС-ийн нөхцөл байдал

ОНХС-ийн үе шат

Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны хувьд 2013 оны ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт одоогоор худалдан авах ажиллагааны шатандаа явж байна. Тус хороонд 3 ажил төлөвлөгдсөн бөгөөд тухайн 3 төслийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулахаар тендер зарласан байна.

ОНХС-ийн хэлэлцүүлгийн үе шатууд



3. Иргэдийн оролцоо

Судалгаанд хамрагдсан дүүргийн албан хаагчдын хувьд иргэдийн оролцоог боломжийн сайн гэж үнэлж байсан бол хорооны түвшний албан хаагчид иргэдийн оролцоог муу байсан гэж үнэлжээ. Ийнхүү муу байсан шалтгааныг зуны улирал болж иргэд амралт зугаалгаар явсантай холбон тайлбарлаж байв.

Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороонд оршин суудаг албан ёсны бүртгэлтэй нийт 30 иргэнийг санамсаргүй түүврийн аргаар сонгож ярилцлага хийв.

1. ЧД, 1-р хорооны иргэдийн ОНХС-ийн санал асуулга, хэлэлцүүлэгт оролцсон байдал

Асуулт	Тийм	Хувь
Та ОНХС-ийн талаарх санал асуулгад оролцсон уу?	10	33,3%
Та ОНХС-ийн талаарх хэлэлцүүлэгт оролцсон уу?	7	23,3%

6. Хэлэлцүүлэгт оролцоогүй иргэдийн шалтгаан



Дээрх хэлэлцүүлэгт оролцоогүй 23 иргэнээс ОНХС-ийн талаарх хэлэлцүүлэг болсон эсэхийг 5

иргэн мэдсэн гэж хариулсан бол 18 нь мэдээгүй байна.


4. Тулгарч буй бэрхшээл

Төлөвлөх

Хорооны удирдлагуудын үзэж байгаагаар иргэдийн оролцоог жигд хангахгүй бол бүлэг иргэд хэлэлцэж тохиролцон хэлэлцүүлэгт бөөнөөрөө оролцож нийтийн бус өөрсдийн эрх ашигт нийцсэн төсөл батлуулах эрсдэлтэй гэж үзэж байна.

Харин иргэд тулгарч буй бэрхшээлүүдийн хувьд хурлын талаарх мэдээлэл авдаггүй, орон нутгийн удирдлага иргэдийн санаа бодлыг сонсдоггүй, сэдвийн талаар мэдээлэлгүй зэргийг дурдаж байна. Мөн судалгаанд оролцсон иргэдийн 40 хувь нь ямар нэгэн бэрхшээл тулгардаггүй гэж хариулсан байна.

7. Шийдвэр гаргах түвшинд оролцоход иргэдэд тулгарч буй бэрхшээл /хувь/



Судалгааны гол дүгнэлт

Орон нутгийн удирдлагууд ОНХС-гийн талаарх мэдээлэл болон хэлэлцүүлгийн зар мэдээг иргэдэд хүргэхдээ, хотод ихэвчлэн хэсгийн ахлагчаар, орон нутагт багийн засаг даргаар дамжуулдаг. Харин судалгаанд оролцсон нийт иргэдийн бараг тал нь төсвийн тухай хууль болон ОНХС-гийн талаар мэдээлэл авдаггүй, мэдэхгүй гэж хариулсан байна. Судалгаанд хамрагдсан орон нутгийн удирдлагуудын ихэнх нь ОНХС-ийн талаарх сургалтанд хамрагдсан тул хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл харьцангуй бага байна гэж хариулжээ.

Нийт судалгаанд хамрагдсан орон нутгийн удирдлагууд бараг бүгд ОНХС-аар дамжин хэрэгжих төсөл хөтөлбөрийг сонгоход иргэдийн оролцоо маш чухал гэж үзэж байна. Ялангуяа ОНХС-ийн хөрөнгийг зөв зохистой зарцуулахад энэ талаарх иргэдийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага байгааг дурдаж байна. Судалгааны дүнгээс үзэхэд хотын иргэдээс илүү орон нутгийн иргэд хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож байгаа нь харагдаж байна. Харин хэлэлцүүлэгт оролцоогүй иргэдийн хувьд ихэвчлэн завгүй байсан, хэлэлцүүлэг

хэзээ болохыг мэдээгүй гэсэн хариултуудыг өгчээ. Орон нутгийн удирдлагуудын зүгээс цаашид хэлэлцүүлэгт оролцох иргэдийг нэмэгдүүлэх, иргэдийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

ОНХС-аар хийгдэх худалдан авах ажиллагааны шатанд хөдөөгийн сумдад тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэх боломжтой аж ахуйн нэгж цөөхөн, байгаа аж ахуйн нэгжүүд нь тухайн тендерийн шалгуурыг хангаж чадахгүй явдал гарч байна. Мөн санхүүжилт төлөвлөгдсөн хугацаанаас хоцорч орж байгаа тул худалдан авах ажиллагаа хугацаандаа хийгдэж чадахгүй байна. Удирдлагуудын дунд буй бас нэг бэрхшээл бол Сангийн яамны сайдын тушаалаар баталсан хөрөнгө оруулахыг хориглосон ажлуудын жагсаалт юм. Иргэдийн төлөвлөсөн ажлууд дунд энэ журамд орсон хориглосон ажлууд их байдаг тул санхүүжүүлэх боломжгүй болдог. Харин иргэд дараа нь тухайн ажлуудын хэрэгжилтийг нэхдэг тул төр иргэн хоёрын хооронд зөрчил үүсдэг гэж удирдлагууд үзжээ.



“ГЕОДЕЗИ, КАРТОГРАФ БОЛОН ГАЗРЫН АЛБАНЫ ИЛ ТОД БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ” КЕЙС СУДАЛГАА



Захиалагч: АНУ-ын Азийн сан, USAID

Хамтрагч: Авлигатай тэмцэх газар


Судалгааны зорилго

Газрын албаны үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах, иргэдэд олгож буй 0.07/0.5/0.35 хүртэлх га газрыг өмчлөх үйл явцтай холбогдох хүндрэл бэрхшээл, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, газрын албаны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмыг боловсронгуй болгох санал боловсруулахад оршино.

Судалгааны зорилт:

1. Газрын албаны үйл ажиллагаа, бүтэц, бүрэлдэхүүн дотоод механизмыг судлах;
2. Газрын албаны үйлчилгээг ил тод байлгахад саад болж байгаа хүчин зүйл шалтгааныг тодорхойлох,
3. Газар өмчлөх үйл ажиллагаанд иргэдэд тулгардаг хүндрэл бэрхшээлийг үе шат болгонд судлах;
4. Газрыг өмчлүүлэх үйл ажиллагааны ил тод байдлыг дээшлүүлэхэд шаардлагатай бодлого, дүрэм журмыг үнэлэх;
5. Газрын албаны үйл ажиллагааны талаар иргэдэд мэдээлэл түгээх, авлигад өртөхөөс урьдчилан сэргийлэх зэрэг болно.

Үндсэн мэдээлэл



Хамрах хүрээ

Нийслэлийн Багануур, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргүүд болон Дархан, Дундговь, Ховд, Хэнтий аймаг.

Авлигатай Тэмцэх Газарт (АТГ) газрын асуудлаар ирүүлсэн өргөдөл, санал гомдол болон Нийслэлийн дүүргүүдийн газрын албанд ирсэн газартай холбоотой шийдэгдсэн өргөдөл гомдлын материалуудаас кейсийг сонгосон.

Судалгааны явцад нийт 14 кейс цугларсан. Кейсийг ашиглахдаа судалгаанд оролцсон хүмүүсийн мэдээллийн нууцлалыг хадгалах үүднээс нэрийн эхний үсгийг оруулсан.

Судалгааны дизайн, арга зүй:

Энэхүү судалгааны ерөнхий дизайн бол олон кейст судалгааны арга юм. Олон кейст судалгааны арга нь “яаж”, “яагаад” гэсэн асуултуудад хариулт авах зорилготой бөгөөд бодит нөхцөл байдал, учир шалтгааныг нарийвчлан авч үзэж шинжлэхэд оршино. Судалгаанд чанарын аргыг үндсэн арга болгож ашиглан, сонгогдсон 7 талбараас олон тооны кейсуудыг гаргаж кейс тус бүрийн онцлог талыг тодруулан, зарим ерөнхий үзүүлэлтээр кейсүүдийг дүгнэн нэгтгэсэн болно.



2013 ОНЫ
8 сараас

2014 ОНЫ
1 сар



343 Иргэн



40 Ганцаарчилсан
Ярилцлага




14 Кейс

Судалгааны гол үр дүн

Судалгаанд хамрагдсан 10 хүн тутмын долоо нь газрын албаараа дамжуулж мэдээлэл авч байна. Энэ мэдээллийн 50 хувь нь Газрын албаны ажилтнуудаар дамжсан.


Судалгаанд хамрагдсан таван иргэн тутмын нэг нь хуулинд заасан хугацаанаас хэтэрч өмчлөх захирамжаа авчээ. Үүнийг хот, орон нутгаар харьцуулж үзвэл Улаанбаатар хотод хуулийн хугацаанаас хэтрэх тохиолдол элбэг гарч байна.

1. Иргэн газар өмчлөхтэй холбоотой мэдээлэл авах эх сурвалж




Иргэн газраа өмчилж авахдаа ойр дотны хүмүүсээрээ дамжуулах тохиолдол гарсан гэж судалгаанд оролцогчдын 5 орчим хувь буюу 14 хүн хариулжээ. Мөн өөрийн эрх мэдэл, нэр хүндийг ашигласан, газрын албаныхан мөнгө нэхсэн, харилцан ашигтай санал тавьж, мөнгө өгч газраа олж авсан хүмүүс байна. Үүнийг хот орон нутгаар нь харьцуулан авч үзвэл, хотод газрын албаныхан мөнгө нэхэх (80 хувь), ойр дотны ажилладаг хүнээс туслалцаа авах (60 хувь), гарыг хүндрүүлэх (нэг тохиолдол) тохиолдол нэлээд гардаг. Харин орон нутагт газрын албатай холбоотой найз нөхөд, танил талаараа яриулах (62.5 хувь), өөрийн эрх мэдэл, нэр хүндийг ашиглах (75 хувь) тохиолдол илүү байна.

2. Та газраа өмчилж авахын тулд бичиг баримтаа бүрдүүлж газрын албанд өгснөөс хойш хэдэн сарын дараа газар өмчлүүлсэн талаарх захирамжийг авсан бэ?



3. Таныг газраа өмчилж авах явцад хүнд суртал, чирэгдэл учирсан уу?



4. Хүнд суртал, чирэгдэл учирсан бол ямар төрлийн хүнд суртал, чирэгдэл учирсан болохыг та хэлнэ үү?



5. Таны бодлоор газрын алба, ажилтнуудын үйл ажиллагаанд оршиж буй нэн даруй засвал зохих дутагдал юу вэ?



Судалгааны гол дүгнэлт

Газар өмчлөх үйл явц түүнд учирч байгаа бэрхшээл: 2003 онд Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль Монголд анх удаа батлагдсанаар өрх бүрт газрыг үнэ төлбөргүйгээр хувьчилж эхэлсэн бөгөөд 2008 онд иргэн бүрт газар өмчилнэ гэж нэмж өөрчилсөн. Үүнтэй холбоотой газрын албаны ачаалал огцом ихэсч өнөөдрийн байдлаар нийт иргэдийн 11.8 хувь нь газраа өмчилж авчээ. Газар өмчлөх ажлын явц нь орон нутаг болон нийслэлийн дүүргүүдэд ялгаатай байгаа бөгөөд тулгарч байгаа бэрхшээл нь ч өөр байна.

Газар өмчлөхтэй холбоотой мэдээлэл, түүний хүртээмж. Иргэдийн 67,6 хувь нь газар өмчлөхтэй холбоотой мэдээллийг харьяа сум, дүүргийнхээ газрын албаны ажилтнуудаас авч байна. Хот ба орон нутгаар нь харьцуулбал орон нутагт газрын албаны ажилтнуудаас мэдээлэл авах нь хотынхоос 20-30 пунктээр өндөр байна. Энэ нь орон нутагт мэдээлэл авах эх сурвалж цөөн, нөгөө талаас газрын албаны ачаалал бага байдагтай холбоотой. Газрын алба иргэдэд мэдээллийг хангалттай өгч чадахгүй байгаа нь дараах 4 үндсэн хүчин зүйлээс шалтгаалж байна. Үүнд, газрын албаны ажилтны буруугаас, бүтэц, зохион байгуулалт оновчгүйгээс, иргэдээс өөрсдөөс нь шалтгаалж, мөнгө төсөв хүрэлцдэггүй гэх мэт. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл иргэдийн мэдээлэл авдаг дараагийн эх сурвалж болж байна.

Иргэд, газар өмчлөхтэй холбоотой бүрдүүлэх баримт бичиг, үе шат. Иргэд, газар өмчлөхтэй холбоотой баримт бичиг бүрдүүлэхэд газрын албаны үйл ажиллагаа ил тод, нээлттэй бус, ажилчид нь хүнд суртал ихтэй, иргэдэд хангалттай мэдээлэл өгдөггүйтэй холбоотойгоор бэрхшээл үүсдэг ажээ. Энэ нь газар өмчлөхтэй холбоотой иргэдийн мэдээлэл дутмаг, мэдлэг ойлголт муу байгаатай холбоотой. Түүнчлэн иргэдэд кадастрын зураг хийлгэхэд тулгарч буй бэрхшээлүүдийн хувьд, нэгдүгээрт, орон нутагт кадастрын компани хүрэлцээгүй; хоёрдугаарт, кадастрын зургийг буруу хийдэг; гуравдугаарт, газар давхардуулж олгодог; дөрөвдүгээрт: ашиг сонирхлын зөрчилтэй зэргийг дурдаж байна.

Газрын алба бичиг баримтыг хүлээж авах, шийдвэрлэх үе шат. Газар өмчлөхтэй холбоотой төрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын бодлого, үялдаа холбоо муу байна. Тиймээс нэг газрыг хоёр хүнд давхардуулан захирамж гаргах тохиолдол гардаг. Мөн цаг хугацаанд нь шийдэж өгөхгүй удах, дараалал үүсэх, захирамж гарахгүй сураггүй болох зэрэг бэрхшээл тохиолдож байна. Нөгөө талаас иргэд хууль бус газар

зөвшөөрөлгүй өөрсдөө дур мэдэн буух, хуулийн дагуу эрүүл мэнд аюулгүй байдлын стандартад нийцэхгүй газрыг өмчилж авах оролдлого хийдэг зэрэг нь газрын албаны үйл ажиллагааны ачааллыг нэмэгдүүлээд зогсохгүй бэрхшээл болдог байна.

Газар өмчлөх гэрчилгээ авах үе шат. Иргэд газар өмчлөх гэрчилгээ авах үе шатанд тулгарах бэрхшээл харьцангуй бага байна. ЗД-ын захирамжийг авснаар өөрийн өмчлөх эрхийг баталгаажсан гэж “буруу ойлгодог” учраас иргэд өмчлөх эрхийн гэрчилгээ авахаар ханддаггүй байна. Мөн сумын иргэд аймгийн төв рүү явж өмчлөх эрхийн гэрчилгээ авах шаардлагатай болдог тул тухай бүрт нь бүртгэлийн газар хандаж гэрчилгээгээ авч чадахгүй байна. УБЕГ-т бүрдүүлэх бичиг баримт ба төлбөрийн хувьд хүндрэл бага байна. Харин Улаанбаатар хотын иргэд УБЕГ-аас үйлчилгээ авахад дараалал их байгаа нь бэрхшээлтэй байна гэжээ.

Газрын албаны үйлчилгээний сэтгэл ханамж, үйлчилгээний чанар хүртээмж. Газрын албаны ажилтнууд хүнд суртал, чирэгдэл гаргадаг гэдэг нь, нийт үйлчлүүлсэн иргэдийн 28.9 хувь нь газраа өмчилж авахын тулд 4-7 хүртэл удаа, 16.9 хувь нь 8 ба түүнээс дээш удаа газрын албанд очсоноос харагдаж байна. Мөн газраа өмчилж авахад бэрхшээл учирсан гэж 23 хувь нь хариулсан бөгөөд хүнд сурталтай холбоотой чирэгдэл учирсан гэж 23.6 хувь нь, мэдээлэлтэй холбоотой бэрхшээл тулгарсан гэж 10.1 хувь нь, газрын албаны ачаалалтай холбоотой гэж 19 хувь, ажлын цагтай холбоотой гэж 12.2 хувь нь хариулжээ. Нийтдээ 26.3 хувь нь газар өмчлөхийг шийдвэрлэж байгаа цаг хугацааг удаан байна гэж шүүмжилсэн байна. Үүнд нөлөөлж буй таван хүчин зүйл байна. Үүнд, иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээнд тогтмол хяналт, мониторинг байхгүй байгаа; газрын албаны ажилтнуудын ажлын ачаалал их; газрын албаны бүтэц, зохион байгуулалтыг үйлчилгээ үзүүлж байгаа иргэдийн тоотой холбоотой уян хатан болгоогүй; хууль, бодлого хоцрогдсон; газрын албаны ажилтнуудын орчин нөхцөлтэй холбоотой байна.

Газрын маргаан. Сүүлийн жилд газар өмчлөх үйл явц эрчимжсэнтэй холбоотойгоор иргэд хоорондын газрын маргааны тоо өсөн нэмэгдэж байна. Ийнхүү газрын маргаан гарч буй шалтгаан нь нэг талаас газрын албаны ажилчдын ажлын хариуцлагагүй, хайхрамжгүй байдалтай, нөгөө талаас иргэдийн буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй.



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН ЯАМ

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА



Захиалагч: Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Яам /Хуучнаар/

Судалгааны зорилго

Төслийн үйл ажиллагааны үр дүнд гарах зорилгыг “Нийслэлийн хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй хүн амд тулгарч буй нийгэм, эдийн засгийн асуудлыг судалж, нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах санал зөвлөмж боловсруулагдсан байна” гэж томъёолсон.

Судалгааны зорилт

- Нийслэлийн хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм, эдийн засгийн хэрэгцээг тодорхойлох судалгаа нь дараах зорилтуудтай болно.
- Нийслэлийн хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хэрэгцээг тодорхойлох
- Нийслэлийн хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эдийн засгийн хэрэгцээг тодорхойлох
- Нийслэлийн хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүргэх нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах санал зөвлөмж гаргах

Үндсэн мэдээлэл



Хамрах хүрээ

Энэхүү судалгаа нь Улаанбаатар хотын 9 дүүрэг 19 хороонд явагдсан ба дараах төслийн зорилтот бүлгийн хүн амыг хамруулсан. Үүнд:

1. Нийслэлийн хөдөлмөрийн насны ХБИргэн
 2. Холбогдох байгууллагуудын мэргэжилтэн:
- Нийслэлийн хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн.
 - Дүүргийн халамж үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн.
 - ТББ, иргэний нийгмийн байгууллагуудын мэргэжилтэн.

Судалгааны дизайн, арга зүй:

Асуулга судалгаа: Асуулга судалгаа нь дараах гол хэсгүүдээс бүрдсэн. Үүнд:

- Эдийн засаг
- Нийгэм
- Эрүүл мэндийн үйлчилгээ
- Нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмж зэрэг болно.

Кейс судалгаа: Анкетын судалгаа авсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс 8 кейсийг сонгон ярилцлага авсан.

Ганцаарчилсан ярилцлага: Энэхүү аргыг бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх асуудлуудад холбоо бүхий төрийн болон төрийн бус 8 байгууллагын холбогдох мэргэжилтнүүдээс авсан. Ганцаарчилсан ярилцлагаар байгууллагууд, институцийн чадавхи болон нөхцөл байдлыг судалсан.



2012 ОНЫ
7 сараас

2013 ОНЫ
1 сар



206 Хөгжлийн
Бэрхшээлтэй Иргэн



8 Ганцаарчилсан
Ярилцлага



8 Кейс

Судалгааны гол үр дүн

Ажил эрхэлдэггүй шалтгааны дийлэнхи хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц дутмаг байгаа шалтгаан эзэлж байна

1: Хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажил эрхэлдэггүй шалтгаан

Ажил эрхэлдэггүй шалтгаан	Хариулсан:	
	Тоо	Хувь
Хөгжлийн бэрхшээлээс шалтгаалан	131	49.2%
Ажилд орохыг хүсдэггүй	6	2.2%
Сурдаг учраас	4	1.5%
Ичиж санаа зовдог болохоор	1	0.4%
Архи уудаг учир	1	0.4%
Ажилд ирж очиход туслах хүн байхгүй учир	5	1.9%
Гэр бүлийнхэн нь зөвшөөрдөггүй	2	0.8%
Хүүхдээ асардаг учир	2	0.8%
Ажил олгогч компаниуд ажилд авдаггүй учраас	42	15.8%
Боловсролын түвшингээс шалтгаалан	13	4.9%
Наснаас шалтгаалан	7	2.6%
Нийгмийн даатгал төлөх шаардлага гардаг учир	1	0.4%
Хөдөлмөрийн хөлс бага байдаг учир	10	3.7%
Тохиромжтой ажлын байр олддоггүй учир	36	13.5%
Дэд бүтцийн асуудлаас шалтгаалан	4	1.5%
Хувиараа бизнес эрхлэхэд зээлийн дэмжлэг байхгүй учир	1	0.4%

Дээрх үр дүнгээс үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй учраас хөдөлмөр эрхлэх боломжгүй байдаг гэж 49.2 хувь нь хариулсан байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд сэтгэл зүйн хувьд өөрсдийгөө буруутгах хандлага их байгааг харуулж байна.

Хөдөлмөр эрхлэлтийн зуучлах үйлчилгээ дутмаг байна.

Судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд ажилгүйдэл их байна. Гэхдээ нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагддаг иргэдийн ажил эрхлэлтийн хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагддаггүй иргэдээс өндөр байна. Энэ нь нийгмийн халамжид хамрагддаггүй иргэд орлогын эх үүсвэргүй, ямар нэгэн тусламж дэмжлэггүй амьдарч байгааг харуулж байна.

Мөн түүнчлэн нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагддаггүй иргэд нь хөгжлийн бэрхшээлийн чадвар алдалтын хувиараа нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагддаг иргэдээс өндөр байна.


Дээрх үр дүнгүүд нь нийгмийн халамжийн үйлчилгээ зорилтот бүлгээ бүрэн хамруулж чадахгүй байгааг харуулж байна.

2: Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдалт



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дийлэнхи нь орлогын баталгаажих түвшингээс доогуур орлогтой иргэд байна.

3: Хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сарын орлогын хэмжээ



Судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 2.4 хувь нь огт орлогогүй, 44.2 хувь нь сард 105.000 хүртэлх төгрөгийн орлоготой иргэд байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дийлэнхи нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой байгааг харуулж байна. Эдгээ бага орлоготой иргэд нь байшин барих, засвар хийх, машин засах гэх мэт тогтмол бус, дуудлагаар ажил эрхэлдэг иргэд байна.

Мөн түүнчлэн судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнхи нь буюу 85.9% нь 280.000 хүртэлх орлоготой иргэд байна. Энэхүү үзүүлэлт нь хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орлого бага байгааг харуулж байна.

Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтэц хүртээмжгүй мөн чанаргүй байна.

4: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийн чанар

Дэд бүтэц	Огт чанаргүй	Чанаргүй	Боломжийн	Чанартай	Маш сайн чанартай	Байдаггүй	Нийт
Налуу зам	9.2%	16.5%	24.8%	3.4%	0.0%	46.1%	100%
Дактил зам	11.2%	14.1%	25.7%	2.9%	0.0%	46.1%	100%
Дуут гэрлэн дохио	5.8%	4.4%	1.9%	0.5%	0.0%	87.4%	100%
Автобусны тусгай шат	3.4%	1.5%	0.0%	0.0%	0.0%	95.1%	100%
Шат	6.8%	5.3%	5.8%	0.0%	0.0%	82.0%	100%
Бариул	8.7%	4.9%	5.8%	0.0%	0.0%	80.6%	100%
Ариун цэврийн өрөө	6.8%	11.2%	7.3%	0.0%	0.0%	74.8%	100%
Цахилгаан шат	4.4%	4.9%	15.5%	3.4%	2.9%	68.9%	100%
Хаалга	2.4%	6.3%	9.7%	0.0%	0.0%	81.6%	100%
Тэргэнцэр \ үйлчилгээний газруудад\	2.9%	3.4%	1.5%	0.0%	0.0%	92.2%	100%
Урсдаг зам болон шат	2.9%	2.9%	14.1%	0.0%	0.0%	80.1%	100%

Нийслэлийн хөдөлмөрийн насны хөгжлийн бэрхшээлтэй иргэд төрийн байгууллагаас бусад байгууллагын дэмжлэгэд хамрагддаггүй.

Судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 65.1 хувь нь дан ганц төрийн байгууллагаас тусламж, дэмжлэг авч байсан

иргэд байна. Харин 9.7 хувь нь олон улсын байгууллагаас дэмжлэг авч байсан, 9.2 хувь нь хувь хүнээс дэмжлэг авч байсан, 5.8 хувь нь төрийн бус байгууллагаас дэмжлэг авч байсан байна. Энэ нь төрийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмждэг гол байгууллага болсоныг харуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мөнгөн дэмжлэг, эмнэлэг эмчилгээний дэмжлэг, хөдөлмөр бэрхлэлтийг дэмжих дэмжлэг илүү хэрэгцээтэй байна.

Судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шаардлагатай дэмжлэгийн хувьд судалгаанд хамрагдагчдын 40.8 хувь нь мөнгөн тусламж, 22.8 хувьд нь эмнэлэг эмчилгээний тусламж, 21.4 хувьд нь хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэг, 7.8 хувь нь эд материалын дэмжлэг, 1.5 хувь нь дээрх дэмжлэгүүд бүгд шаардлагатай гэж үзсэн байна. Энэхүү үр дүн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөнгөлөлттэй үйлчилгээ, материаллаг дэмжлэгээ илүүтэйгээр мөнгөн тусламжийг илүүд үзэх хандлагатай байгааг харуулж байна

“ЗАЛУУЧУУД, ХӨДӨЛГӨӨНТ ХҮН АМ БОЛОН ЭРСДЭЛТ БҮЛГИЙН ХҮН АМЫГ ХДХВ/ДОХ-ООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТӨСӨЛ” СУУРЬ СУДАЛГАА




Захиалагч: НҮБ-ын Хүн Амын сан Судалгааны зорилго

Төслийн төгсгөлийн үнэлгээ (2016 онд хийгдэх) хийхэд шаардлагатай суурь үнэлгээний мэдээллийг цуглуулж, тодорхойлох зорилгоор Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM) энэхүү төслийн суурь судалгааг зохион байгуулж байна. Энэ хүрээнд төслийн суурь судалгаанд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

1. Төслийн зорилтот бүлгүүд буюу хөдөлгөөнт хүн ам, ЭБҮ, залуучуудын дундах ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох;
2. Зорилтот бүлгийнхний эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний эрэлт хэрэгцээ, хүртээмжийг тодорхойлох;
3. Төслийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, амжилттай хэрэгжихэд шаардлагатай санал зөвлөмжийг боловсруулах

Үндсэн мэдээлэл



Хамрах хүрээ

Улаанбаатар, Дархан, Өмнөговь,
Ховд, Дорноговь, Эрээн/БНХАУ/

Судалгааны дизайн, арга зүй:

Төслийн судалгаанд шаардагдах мэдээллийг цуглуулахын тулд судалгаанд чанарын болон тоон аргуудыг хослуулан ашигласан. Тухайлбал, зорилтот бүлгийнхний мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх, эрүүл мэндийн боловсрол үйлчилгээний эрэлт хэрэгцээ, түвшинг тогтоох тоон үзүүлэлтээр хэмжигдэх шалгууруудад асуулгын судалгааны аргыг ашигласан. Харин зорилтот бүлгийн эрүүл мэнд, нийгэм, соёлын эрэлт хэрэгцээний чиг хандлага, энэ талын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын чадавхи, тулгарч буй бэрхшээлүүдийг тодорхойлох, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаарх ойлголт, зорилтот бүлгүүдийн эрсдэлт зан үйл зэргийг нарийвчлан судлахын тулд ганцаарчилсан ярилцлага, фокус бүлгийн ярилцлагын аргуудыг голчлон ашиглав.



2012 ОНЫ 11 сараас **2013** ОНЫ 7 сар



1024 Асуулга



101 Ганцаарчилсан Ярилцлага




9 Фокус бүлгийн Ярилцлага


Судалгааны гол үр дүн

Залуучууд

Судалгааны үр дүнгээс танилцуулбал залуучуудын дунд ХДХВ/ДОХ-ын талаар сонссон хувь 93.6 хувьтай байгаа бөгөөд энэ нь Харуулдан тандалтын судалгаатай (ХТС-2011) ойролцоо, БЗДХ-ын талаарх сонсон хувь нь 93.6 хувьтай байгаа нь ХТС-2011-тай харьцуулахад бага байна. Залуучуудын халдвар дамжихаас сэргийлэх арга замыг зөв нэрлэсэн хувь бага (52.9) ХТС 2009 оны үр дүнтэй харьцуулахад доогуур байна. ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэг харьцангуй сайн байгаа хэдий ч залуучуудын 30.3 хувь нь ХДХВ/ДОХ-ын талаар эерэг хандлагатай байна.



Судалгаанд хамрагдсан залуучуудын хувьд 65 хувь нь архи согтууруулах ундаа огт хэрэглэдэггүй гэж хариулсан бол, 33 хувь нь тодорхой хэмжээнд хэрэглэдэг хэмээн хариулт өгсөн байна. Архи, согтууруулах ундаа хэрэглэдэг залуучуудын 62 хувь нь тохируулж, 32 хувь нь амсах төдий хэрэглэдэг гэж хариулсан бол, 6 хувь нь хэтрүүлж уудаг гэсэн хариултыг өгсөн.



Залуучуудын дунд тохиолдлын бэлгийн хавьтал дахь бэлгэвчийн хэрэглээний түвшин бага (эрэгтэй-38.1%, эмэгтэй-21.1%) байна. Анхны бэлгийн хавьтлын үед дэх бэлгэвчийн хэрэглээ, сүүлийн бэлгийн хавьтал дахь бэлгэвчийн хэрэглээ 51 хувиас доогуур байгаа нь харагдаж байгаа бөгөөд, хүйсээр нь харьцуулан үзвэл залуу эмэгтэйчүүдийн хувьд илүү эрсдэл байна.


Судалгаанд хамрагдсан залуучуудын олонхи (81.9%) нь интернет сүлжээ, ялангуяа facebook, youtube зэрэг сайтуудыг ашиглаж мөн мэдээлэл авдаг бөгөөд энэ нь чөлөөт цаг ашиглалтын хувьд ТВ үздэг (87%), интернет ашигладаг (81.7%), кино үзэх (89.7%), гэсэн хариулт өндөр байна.

Залуучуудын дунд эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдахад тулгарч буй гол бэрхшээл нь эрүүл

мэндийн үзлэг, үйлчилгээний үнэ, үйлчилгээний хүнд суртал, эрүүл мэндийн байгууллагын байршил хол зэрэг асуудлууд байна.

Хөдөлгөөнт хүн ам

Хөдөлгөөнт хүн амын хувьд ХДХВ/ДОХ-ын талаар сонссон хувь (96%), БЗДХ-ын талаарх сонссон хувь (92.4%) байгаа нь бусад бүлгүүдийн үр дүнтэй ойролцоо байна. ХДХВ/ДОХ-ын халдвараас сэргийлэх аргыг мэдэж байгаа хувь өндөр (61%) байна. Энэхүү зорилтот бүлгийн дунд ХДХВ/ДОХ-н талаарх хандлага эерэг биш байгаа нь (61%) судалгааны үр дүнгээс харагдаж байна.



Хөдөлгөөнт хүн амын хувьд архи согтууруулах ундааны хэрэглээ өндөр байна. Хөдөлгөөнт хүн амын дунд сүүлийн 12 сарын хугацаанд тохиолдлын бэлгийн хавьталд орсон хувь (22.8%) өндөр байгаа бөгөөд, тохиолдлын бэлгийн хавьтлын үед бэлгэвч хэрэглэсэн хувь (40.3%) бага байгаа нь энэ бүлэгт бэлгийн замаар халдвар авах эрсдэл өндөр байгааг харуулна.

Хөдөлгөөнт хүн амын хувьд хөдөлгөөнт шинжтэй холбоотойгоор тэдгээрийн ажлын талбар буюу хөдөлгөөний бүсэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага байхгүй эрүүл мэндийн сургалт, үзлэг, шинжилгээнд тогтмол хамрагдаж чаддаггүй бөгөөд ХДХВ/ДОХ, БЗДХ-ын талаар мэдээллээ ихэвчлэн телевиз (81%), радио (59)-оос авдаг байна.

Эмэгтэй биеэ үнэлэгчид:

Эмэгтэй биеэ үнэлэгчдийн хувьд олонх нь залуу, гэр бүлгүй, боловсрол багатай мөн шилжилт хөдөлгөөн ихтэй эмэгтэйчүүд байна. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн хувьд ХДХВ/ДОХ (100%), БЗДХ (97.9%)-ын талаар сонсч байсан хувь бусад бүлгүүдтэй харьцуулахад өндөр байна. Харин ХДХВ-н халдвараас сэргийлэх аргуудыг зөв нэрлэсэн хувь (61%) бөгөөд мэдлэг мэдээлэл харьцангуй сайн байлаа. Энэхүү бүлгийн дунд ХДХВ/ДОХ-ын талаар эерэг хандлагатай хувь бусад бүлэгтэй харьцуулахад харьцангуй өндөр (43%) байна.



ХДХВ/ДОХ-ын талаар мэдээлэл авсан эх сурвалжийн олонхийг албан ёсны эх сурвалж болох эрүүл мэндийн байгууллага (75.9%), ТББ (58.2%), үе тэнгийн сургагчид (46.1%), тараах

материал (56.4%), сургалт семинар (55.0%) эзэлж байна.

Долоо хоногт нэг буюу түүнээс олон удаа архи согтууруулах ундаа хэрэглэдэг хувь (52.4%) маш өндөр байна. Эмэгтэй биеэ үнэлэгчдийн хувьд бэлгэвчийн хэрэглээ бусад бүлэгтэй харьцуулахад харьцангуй өндөр (72%) байгаа хэдий ч бүлгийн онцлогийг харгалзвал хангалтгүй үзүүлэлт юм. Бэлгэвчийн хэрэглээ бага байгаатай холбоотойгоор ЭБҮ-ийн дунд хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт (60%) ихээхэн байна. Энэхүү бүлгийн 20 хувь нь, ХДХВ/ДОХ-ын шинжилгээнд хамрагдсан байна.

Судалгааны гол дүгнэлт

Залуучууд

- Залуучууд ХДХВ/ДОХ-ын талаар мэдээлэл сайтай ч БЗДХ-ын талаарх мэдээлэл багатай байна. Үүнээс үүдэн сүүлийн жилүүдэд ХДХВ/ДОХ-ын талаарх мэдээлэл, түүнээс сэргийлэх сургалт сурталчилгааны ажил сайн хийгдэж БЗДХ-ын талаарх мэдээл, сургалт сурталчилгааны ажил орхигдсон гэж дүгнэж болох юм.
- Залуучуудын ХДХВ/ДОХ-ын талаарх хандлага эерэг биш байна. Дөрвөн янзын асуудлаар хандлагыг тодруулж хэмжихэд бүх дөрвөн асуултад эерэг хариулт өгсөн залуучуудын эзлэх хувь дөнгөж 30% байна. ХДХВ/ДОХ өвчний халдвар авсан хүнд хандах хандлага ч эерэг биш байлаа. Энэ сөрөг хандлага нь тухайн өвчнөөс айх айдас байсаар байгааг харуулахын зэрэгцээ энэ талаар мэдлэг багатай, мэдээлэл муутай байгааг давхар баталж байна.

Хөдөлгөөнт хүн ам

- Хөдөлгөөнт хүн амын ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэг доогуур байна: Хөдөлгөөнт хүн амын дундах ХДХВ/ДОХ-ын талаарх цогц мэдлэгтэй хүмүүсийн эзлэх хувь харьцангуй доогуур байна.
- Тохиолдлын бэлгийн хавьталд орох эрсдэл өндөр байна. Тохиолдлын бэлгийн хавьталд орохдоо бэлгэвч хэрэглэсэн хувь хангалтгүй байгаа нь халдвар авах өндөр эрсдэлтэй байгааг харуулна. Ялангуяа хөдөлгөөнт эрчүүд, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тохиолдлын бэлгийн хавьталд орсон хувь өндөр, энэ үедээ бэлгэвч хэрэглэхээс татгалздаг байдал нь өндөр эрсдэлийг дагуулж байна.
- ХДХВ/ДОХ-ын халдвар бэлгийн замаар дамжихаас сэргийлэх арга замыг мэдэж байгаа ч зан үйл нь эрсдэлтэй байна. ХДХВ/ДОХ-оос сэргийлэх дадал бүрэн төлөвшөөгүй, зан үйлийн хувьд эрсдэлтэй байна. Мэдлэг

болон зан үйлийн хооронд зөрүүтэй байдал байсаар байна.

Эмэгтэй биеэ үнэлэгчид

- ЭБҮ-ийн дийлэнх нь боловсрол багатай, ажилгүй, гэр бүлгүй, залуу эмэгтэйчүүд бөгөөд тэдний 10 хувь нь биеэ үнэлэлтийг үндсэн ажлаа гэж үздэг байна. Тэдний ихэнх нь огт гэрлэж байгаагүй, эсвэл нөхрөөсөө тусдаа амьдардаг, шилжилт хөдөлгөөн ихтэй эмэгтэйчүүд бөгөөд дийлэнх нь бага орлоготой төдийгүй тэдний гэр бүлийн нэг хүнд ногдох сарын орлого амьжиргааны баталгаажих доод түвшингээс бага байна.
- Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 5 хувь нь БЗДХ авсан үед илрэх шинж тэмдгүүдийг огт мэдэхгүй байна. Мөн судалгаанд хамрагдсан ЭБҮ-ийн гуравны нэг хүрэхгүй хувь нь ХДХВ, ДОХ-ын талаар цогц, зөв мэдлэгтэй байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.
- Судалгаанд хамрагдсан ЭБҮ-ийн дунд архи, согтууруулах ундааны хэрэглээ их байгаа төдийгүй мансууруулах бодисын хэрэглээ нэмэгдэж байна. Судалгаанд хамрагдсан ЭБҮ-ийн 24.7 хувь ямар нэгэн байдлаар хар тамхи хэрэглэж үзсэн бөгөөд судсаар хар тамхи мансууруулах бодис хэрэглэхдээ зүү тариураа хувааж хэрэглэсэн тохиолдол нэг байна.
- Судалгаанд хамрагдсан ихэнх ЭБҮ бусдын нөлөө дарамтын дор, мөнгө олох, гэр бүлээ тэжээх зорилгоор анх биеэ үнэлжээ. Мөн судалгаанд хамрагдсдын 40 гаруй хувь нь “зуучлагч” эсвэл “босс”-той байна.
- Судалгаанд хамрагдсан ЭБҮ-ийн дунд бэлгэвчийн тогтмол хэрэглээ хангалтгүй байна. Түүнчлэн судалгаанд хамрагдсан ЭБҮ-ийн дунд эмэгтэй бэлгэвчийн олдоц муу, хэрэглээ хангалтгүй байна.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ТА 7175-МОН “АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ДЭД БҮТЦИЙН ТӨСЛҮҮД БА УУЛ УУРХАЙН САЛБАРТ ХДХВ/ДОХ-ООС УРЬДЧИЛСАН СЭРГИЙЛЭХ ТӨСӨЛ”




Захиалагч: Азийн Хөгжлийн Банк

Судалгааны зорилго

Төслийн хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь төсөл хэрэгжүүлэгч нэгжийн хэрэг эрхлэх газрын үйл ажиллагаанд туслахуйц мэдээллээр хангах, Төсөл хэрэгжүүлэгч нэгж болон аймаг тус бүр дэх төслийн зохицуулагч нарын явуулж буй үйл ажиллагаа нь хүлээгдэж буй үр дүн, үр дагавар, үр нөлөөнд хүрч, ахиц гаргаж буй эсэхийг баталгаажуулах, аймгийн болон төслийн түвшин дэх амжилттай, болон сургамжтай туршлагуудыг тодорхойлоход оршиж байсан.

Үндсэн мэдээлэл



Хамрах хүрээ

Төслийн хүрээнд хэрэгжсэн суурь судлагаа нь төслийн зорилтот 3 аймгийн 23 сумын төслийн зорилтот хүн амын мэдлэг, хандлага, дадлыг үнэлэхэд чиглэж байсан юм. Үүнд :

Дорноговь аймаг Даланжаргалан,
Айраг, Эрдэнэ, Өргөн, Сайншанд,
Замын-Үүд, Алтанширээ, Их хэт сум
Ховд аймаг Булган, Үенч, Манхан, Буянт,
Эрдэнэбүрэн, Жаргалант, Алтай сум
болон “Ярант” хилийн боомт, Мөст,
Дөргөн болон Мянгад сум
Өмнөговь аймаг Даланзадгад, Ханбогд,
Цогтэций сум, “Оюутолгой”ХК,
“Энержи Ресурс” ХК, Номгон,
Баян-Овоо сум

Судалгааны дизайн, арга зүй:

Төслийн хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцооны хүрээнд дараах хэд хэдэн төрлийн индикаторуудыг ашигласан.

- Үр нөлөөний индикатор. Энэ нь төслийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүрэн бус зарим дунд хугацааны үр нөлөөг хэмждэг юм. Үүнд төслийн төгсгөл шатанд заавал хүрсэн байхаар зорилтууд хүлээгддэггүй.
- Үр дагаварын индикатор. Энэ нь илүү богино хугацаанд ажиглагддаг бөгөөд (таамаглал, эрсдэлийн үзүүлэлтийг тооцон) төслийн үйл ажиллагаанаас шууд гарч болох үр дүнг хэмждэг. Холбогдох зорилтууд нь төслийн эцэс гэхэд хэрэгжих боломжтой байх ёстой.
- Үр дүнгийн индикатор. Үүнд бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, зан үйлийн өөрчлөлт гэх мэт төслийн хүрээнд гаргаж буй үйл ажиллагаа хамруулна.

Төслийн хяналт шинжилгээ, үнэлгээ нь дараах 3 бүрэлдэхүүнээс бүрднэ. Үүнд:

1. Гүйцэтгэлийн хяналт шинжилгээ, үнэлгээ
 2. Хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ
 3. Судалгаа
- Бүрэлдэхүүн тус бүр нь бие биентэйгээ уялддаа холбоо бүхий төслийн хэрэглэгдэхүүн тус бүийн хэрэгцээ шаардлагад үндэслэн нарийвчлагдан боловсруулагдсан.
- Төслийн хяналт шинжилгээ, үнэлгээний ерөнхий хүрээг доорх дүрсээс харна уу.



2010 ОНЫ
6 сараас

2013 ОНЫ
11 сар



2976 Асуулга

Судалгааны гол үр дүн

Гүйцэтгэлийн мониторинг

АХБ болон Засгийн газар харилцан санал нэгдэж батласан төслийн хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцооны дизайн нь төслийн гүйцэтгэлийг хэмжих үр нөлөө, үр дагавар, үр дүнгийн индикаторуудыг болон зорилтуудыг агуулсан цогц тогтолцоо болж байна. Төслийн хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцооны дизайнд тусгагдсан индикаторуудын дагуу цуглуулсан мэдээл дээр суурилан дараах дүгнэлтүүдийг хийж болохоор байна.

- Төслөөс хүлээгдэж буй гол үр нөлөө нь “Дэд бүтэцтэй холбоотой гарч буй ХДХВ/ДОХ-ын халдварын тархалтаас урьдчилсан сэргийлэх” байсан. ХДХВ/ДОХ-ын бүртгэгдсэн тархалтын тохиолдлын тоо өссөн хэдий боловч, зорилтот жилүүд дэх насанд хүрэгчдийн дундах тархалтын тоо 0.02-оос бага байсан байна. Тиймээс, дэд бүтцийн хөгжилтэй холбоотойгоор өндөр эрсдэлтэй орчин бүрдсэн байгаа боловч тархалт нэмэгдэхгүй байгаа нь ХДХВ/ДОХ-ын тархалтаас урьдчилан сэргийлэхэд тодорхой хувь нэмэр болсон гэж таамаглаж байна.
- Үндэсний түвшинд төслөөс хүлээгдэж байсан гол үр дагавар болох бодлогын баримт бичиг болон сургалтын модулыг төслийн хүрээнд боловсруулж, хэрэгжүүлсэн.
- Сонгогдсон аймгуудын түвшинд хүлээгдэж байсан үр дагавар болох Дэд бүтцийн хөгжилтэй холбоотойгоор ХДХВ/ДОХ, БЗДХ-н халдварын эрсдэл бүүрсан байх гэсэн үзүүлэлт нь зарим аймаг болон зорилтот бүлгүүдийн дунд хэрэгжсэн байна.
- Хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцооны дизайнаар хүлээгдэж байсан олонхи үүргүүд нь төслийн гол 3-н бүрэлдэхүүний хүрээнд хэрэгжиж, зорилгодоо хүрсэн байна.

Мөн түүнчлэн, энэхүү төсөл нь үндэсний стратегийн хөтөлбөрийн хэрэгжилтэд бодитой хувь нэмэр оруулсаныг харуулж байсан. Ялангуяа дэд бүтцийн салбартай холбоотойгоор, тодорхой аймгуудын түвшин дэх холбогдох индикатруудаас харагдаж байв. Сонгогдсон аймгууд дах ХДХВ/ДОХ/БЗДХ-н байдал нь олон хүчин зүйлээс хамаарах бөгөөд үүнийг дан ганц төслийн

индикаторын хүрээнд тайлбарлаж болохгүй юм.

Хэрэгжилт

Хэрэгжилтийн түвшинд төсөл нь үндэсний болон аймгийн түвшинд аль алинд нь төлөвлөсөн үйл ажиллагаа, бүтээгдэхүүнийг хангалттай хэмжээнд гүйцэтгэсэн. Энэхүү хэрэгжилтийг үнэлэх индикаторуудад төслийн хүрээнд сургагдсан үе тэнгийн сургагч багш нарын тоо, төслөөс зохион байгуулсан сургалтын тоо, зан үйлийг өөрчлөх нөлөөллийн ажлуудын тоо, үр дүнг тархаасан ТВ, радио хөтөлбөрүүдийн тоо, тархаасан бэлгэвчийн тоо, сайн дурын зөвлөгөө шинжилгээний төвийг дэмжих ажилласан үйл ажиллагаануудын тоо гэх мэт индикаторууд багтсан.


Бүрэлдэхүүн 1 болох ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн байн. Бүрэлдэхүүн 2-н хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагаанууд болон Институцийг чадавхижуулах ажлын хүрээнд зорилтот бүлэгт чиглэсэн зан үйлийг өөрчлөх сургалтын үр дүнд бодлогын баримт бичиг, удирдамжууд гарсан бөгөөд, бодлого төлөвлөгч болон шийдвэр гаргачдын дунд уулзалт зөвлөгөөнүүдийг зохион байгуулсан. Мөн түүнчлэн Бүрэлдэхүүн 3-н хүрээнд ХШҮТ-г боловсруулж, үүнийг институцийг судлахад ашиглагдсан. Төслийн хэрэгжилтийн шатанд, төлөвлөөгүй байсан гэнэтийн нөхцөл байдлаас үүдэн төсөл нь төлөвлөсөн цаг хугацаанд үйл ажиллагаа явуулах боломжгүй байсан гэдгийг дурдах хэрэгтэй.

Судалгаа

ХШҮТ-ны хүрээнд төслийн аймгуудад хэрэгжүүлсэн суурь болон харьцуулсан судалгааны үр дүнг дараах дүрсэд багцлан үзүүлж байна. Энэхүү үр дүн н зорилтот бүлгийн үр дүн юм. ХШҮТ-д дараах гол 5 үзүүлэлт нь төслийн үр дүнг үнэлэхэд ашиглагдсан юм.


Төслийн ХШҮТ-ны үнэлгээг хураангуйлан үзвэл, судалгааны мэдээллүүд нь төлийн үр нөлөө, үр дагавар болон үр дүнд хүрсэн гэж хэлэх үндэстэй байна.

Хөтөлбөрт хамрагдалт (хувиар)




ХДХВ/ДОХ-оос сэргийлэхүйл ажиллагаанд оролцсон хувь нь зам барилгын ажилчид болон өрх толгойлсон эмэгтэйчүүдийн хувьд суурь судалгаанаас хойш өөрчлөгдөөгүй байна. Харин ХДХВ/ДОХ-оос сэргийлэх үйл ажиллагаанд оролцсон залуучуудын хувь буурсан хэдий ч уул уурхайн ажилчид болон үйлчилгээний цэгийн эмэгтэй ажилчдын хувьд энэхүү үзүүлэлт нь суурь судалгаанаас илүү өссөн байна. Энэхүү тоо нь статистикийн хувьд үнэн баттай юм.

Цогц мэдлэг(хувиар)



Цогц мэдлэгтэй /нийтлэг ташаа ойлголтыг үгүйсгэж чадсан, бэлгийн замаар халдвараар урьдчилан сэргийлэх аргыг зөв нэрлэсэн/ үйлчилгээний цэгийн ажилчид болон залуучуудын хувь өссөн байна. Уул уурхайн ажилчдын хувьд нийтлэг ташаа ойлголтыг үгүйсгэж чадсан, бэлгийн замаар халдвараар урьдчилан сэргийлэх аргыг зөв нэрлэсэн хувь нь 5 хувиар өссөн байна. Гэвч энэхүү өсөлт нь статистикийн хувьд ач холбогдолгүй байна.($t = -0.340, p = 0.734$). Өрх толгойлсон эмэгтэйчүүд болон үйлчилгээний цэгийн ажилчдын хувьд энэхүү үзүүлэлт буурсан боловч, энэхүү бууралт нь статистикийн хувьд ач холбогдолгүй байна.


Зерэг хандлага (хувиар)



Судалгааны хүрээнд өрх толгойлсон эмэгтэйчүүдийн зэрэг хандлагыг тодорхойлохдоо 4 асуултыг асууж тодорхойлсон бөгөөд эдгээр асуултад зэрэг хариулт өгсөн судалгаанд оролцогчдыг зэрэг хандлагатай хэмээн тодорхойлсон. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн хувьд суурь судалгаанаас 11.7 хувиар өссөн($t = -2.47, p = 0.02$) байна. Байршлаар нь харьцуулан үзвэл, Дорноговь аймгийн судалгаанд оролцогчдын хувьд 47.4 хувиар, Өмнөговь аймгийн хувьд 22.9 хувиар өссөн, зэрэг зэрэг хандлагатай судалгаанд оролцогчид тус тус өссөн байна. Төслийн зорилотот бүлгийн үйлчилгээний цэгийн эмэгтэй ажилчдын хувьд зэрэг хандлагатай хувь нь 11.4 хувиар өссөн байна. Мөн түүнчлэн залуучуудын хувьд төслийн аймгуудын зорилотот бүлгийн залуучуудын хувьд өссөн үзүүлэлттэй байна.

Уул уурхайн ажилчид болон зам барилгын ажилчдын хувьд ХДХВ/ДОХ-н талаар зэрэг хандлагатай хувь буурсан харагдаж байна. Гэвч энэ нь статистикийн хувьд ач холбогдолгүй байна.

СЗДШ-д хамрагдалт (хувиар)



ХДХВ/ДОХ-н шинжилгээнд хамрагдсан, хариугаа мэдэж байгаа өрх толгойлсон эмэгтэйчүүдийн хувьд суурь судалгаанаас өссөн /статистикийн хувьд ач холбогдолтой/ байна. Байршлаар нь харьцуулж үзвэл зорилотот бүлгийн Дорноговь аймгийн өрх толгойлсон эмэгтэйчүүдийн хувьд үр дүн нь адил байсан бол, Өмнөговь аймгийн хувьд 10 хувиар өссөн, Ховд аймагт 16.7 хувиар өссөн зэрэг үр дүн харагдаж байна. Гэвч ХДХВ/ДОХ-н шинжилгээнд хамрагдсан хариугаа мэдэж буй уул уурхайн ажилчид болон залуучуудын хувь буурсан үзүүлэлттэй байна. Мөн зам барилгын ажилчид болон үйлчилгээний цэгийн эмэгтэй ажилчдын хувьд энэ үзүүлэлтэд төдийлөн өөрчлөлт гараагүй байна.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРААС ИРГЭДЭД ҮЗҮҮЛЖ БУЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МОНИТОРИНГ



Захиалагч: Хууль Зүйн Яам

Хамтрагч: Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар


МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО

Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын (УБЕГ) хуулиар тогтоосон чиг үүргийн дагуу иргэдэд хүргэж буй үйлчилгээний чанар, хүртээмжтэй байдалд мониторинг хийж цаашдын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмж өгөхөд судалгааны гол зорилго оршино. Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэв.

СУДАЛГААНЫ ЗОРИЛТ

1. УБЕГ, иргэдэд хүргэж буй үйлчилгээний чанар, хүртээмжтэй байдлыг хуулиар тогтоосон чиг үүргийн дагуу үнэлэх. Ингэхдээ дараах бүрэлдэхүүн хэсгүүдээр тус тусад нь үнэллээ.
 - а. Байгууллагын бүтэц, зохион байгуулалтын талаарх үнэлгээ
 - б. Үйлчилгээний чанарын талаарх үнэлгээ
 - в. Үйлчилгээний хүртээмжтэй байдлын үнэлгээ
 - г. Үйлчилгээний орчин нөхцөлийн үнэлгээ
 - д. Үйлчилгээний ажилтны ёс зүй
2. УБЕГ-ын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн бодлогын болон үйл ажиллагааны санал зөвлөмж боловсруулах

Үндсэн мэдээлэл



Хамрах хүрээ

Монгол улсын дөрвөн аймаг, Улаанбаатар хотын гурван дүүрэг.

Судалгааны дизайн, арга зүй:

УБЕГ-ын үйл ажиллагааг иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байгаа улс, нийслэл, дүүрэг, аймаг, сум гэсэн бүх шатны алба хэлтсээс үйлчилгээ авсан иргэдтэй стандартчилагдсан ярилцлага хийх, мөн аж ахуйн нэгж болон тэдэнд үйлчилгээ үзүүлж байгаа УБЕГ-ын удирдлагуудтай ганцаарчилсан ярилцлага хийх, тухайн үйлчилгээ үзүүлж буй газарт судлаач өөрийн биеэр очин ажиглалт хийх зэргээр мэдээлэл цуглуулж үнэлсэн.



2013 ОНЫ
5 сараас

2013 ОНЫ
6 сар



160 Үйлчлүүлэгч



21 Ганцаарчилсан
Ярилцлага



64 Баримт бичгийн
судалгаа

МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГААС ИРГЭДЭД ХҮРГЭДЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МОНИТОРИНГ



Захиалагч: Цагдаагийн Ерөнхий Газар

Хамтрагч: Хууль Зүйн Яам


МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО

Энэхүү хөндлөнгийн судалгааны ажлын зорилго нь иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, шуурхай байдал, хүртээмжийн бодит байдлыг цагдаагийн байгууллагын хуулиар тогтоосон чиг үүргийн дагуу үнэлж, түүнд дүн шинжилгээ хийн цаашид өөрчлөх бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлоход оршино.

СУДАЛГААНЫ ЗОРИЛТ

1. ЦЕГ иргэдэд хүргэж буй үйлчилгээний чанарыг хуулиар тогтоосон чиг үүргийн дагуу үнэлэх. Ингэхдээ дараах хүрээнд үнэлнэ.
 - а. Байгууллагын бүтэц, зохион байгуулалт
 - б. Үйлчилгээний чанар, хүртээмж
 - в. Албан хаагчийн ёс зүй
2. ЦЕГ-ын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн бодлогын болон үйл ажиллагааны санал зөвлөмж боловсруулах.

Үндсэн мэдээлэл



Хамрах хүрээ

Монгол улсын хоёр аймаг, Улаанбаатар хотын хоёр дүүрэг.

Судалгааны дизайн, арга зүй:

Үйлчилгээний чанарт нөлөөлж буй хүчин зүйлүүдэд дүн шинжилгээ хийсэн. Тухайлбал, үйлчилгээний шуурхай байдал гэдэг шалгуур үзүүлэлт нь хүний нөөц, ачаалал зэрэг бусад хүчин зүйлстэй нийлж үйлчилгээний хүртээмжийг тодорхойлох бөгөөд энэхүү үйлчилгээний хүртээмжтэй байдал гэх ойлголт нь байгууллагын бүтэц зохион байгуулалт, хууль эрх зүйн нөхцөл байдал, ёс зүй зэрэг ойлголттой хамт үйлчилгээний чанарыг илэрхийлнэ. Ингэснээр тухайн байгууллагын үйлчилгээ “Сайн”, эсвэл “Муу” гэдгийг үнэлэх боломжтой болох юм.



2013 ОНЫ
8 сараас

2013 ОНЫ
11 сар



270 Иргэн



58 Ганцаарчилсан
Ярилцлага


30 Өмгөөлөгч
Прокурор

28 Цагдаагийн
байгууллагын
удирдлага



10 Баримт бичгийн
судалгаа

“ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ” СУДАЛГАА




Захиалагч: Монгол Улсын Хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөрийн судалгааны институт
Судалгааны зорилго

Энэхүү судалгаа нь хүн амын нягтрал, аж ахуй нэгжид ажиллагсдын тоо, ажлын байрны хэлбэр, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдалд үнэлгээ өгч, бодлого боловсруулагчдад хандсан санал, зөвлөмж боловсруулах зорилготой.

Судалгааны зорилтууд

1. Хөдөлмөрийн тухай хуулинд туссан ажилтан, ажил олгогчийн нийтлэг эрх, үүрэг (ажлын нөхцөл, ажил, амралтын цаг, цалин хөлс, нийгмийн хангамж, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа) хэрхэн хангагдаж байгааг судлах
2. Хөдөлмөрийн тухай хуулинд туссан ажил олгогчдын болон ажилтны төлөөллийн байгууллагаар дамжуулан байгуулагдсан хамтын буюу тарифын гэрээ хэлэлцээр, түүний хэрэгжилтийн түвшинг тодорхойлох
3. Ажлын байран дахь хөдөлмөрийн гэрээ, түүний хэрэгжилтийн түвшинг судлах

Үндсэн мэдээлэл



Хамрах хүрээ

Судалгааны түүврийн хүрээг Монгол улсын хэмжээнд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын жагсаалтаас бэлдсэн. Түүврийн нэгжийг аймаг, нийслэл; сум, дүүрэг; аж ахуй нэгж, судалгаанд оролцогч иргэн гэсэн 4 шатлалын дагуу сонгосон.

Судалгааны түүврийн хүрээг бизнес регистрийн сангийн 2012 оны жилийн эцсийн тайлан, 2013 оны 1 дүгээр улирлын Х тайланг хассан жагсаалтаас тогтоосон. Түүвэрт аж ахуйн нэгжийн эдийн засгийн үйл ажиллагааны салбар болон ажилтны тоог харгалзсан.



2013 ОНЫ
8 сараас

2013 ОНЫ
11 сар



504 Ажил олгогч

1004 Ажилтан

70 Туслах малчин



14 Төлөөллийн байгууллага



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

“ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН ТАЛААРХ ОЛОН НИЙТИЙН ХАНДЛАГА” ОЛОН УЛСЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА



Захиалагч: Швейцарийн Хөгжлийн Агентлаг

Хамтрагч: **Стивен Фиш** /Улс төрийн шинжлэх ухааны профессор, Беркли, Калифорнийн Их Сургууль/

Даниел Луссиер /Улс төрийн шинжлэх ухааны дэд профессор, Гриннел коллеж/


Роуз МкДермотт /Улс төрийн шинжлэх ухааны профессор, Брауны Их Сургууль/

Судалгааны зорилго

Олон улсын харьцуулсан судалгааны зорилго нь: Улс орнуудад нийгмийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд жендэрийн эрх тэгш байдлыг хэрхэн тусгах талаар суурь мэдээлэл бүрдүүлэх явдал юм.

Монгол улс дахь судалгааны зорилго нь: Монгол улс дахь жендэрийн эрх тэгш байдлын талаарх олон нийтийн хандлагыг тодорхойлох явдал юм.

Үндсэн мэдээлэл



Хамрах хүрээ

1. Улаанбаатар хотын 9 дүүрэг
2. Дархан-Уул аймаг
3. Эрдэнэт хот
4. Сэлэнгэ аймаг
5. Баян-Өлгий аймаг
6. Ховд аймаг
7. Хөвсгөл аймаг
8. Өмнөговь аймаг
9. Дорноговь аймаг
10. Сүхбаатар аймаг



2013 ОНЫ
4 сараас

2014 ОНЫ
3 сар



1500 Иргэн

УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫН СУУРЬ СУДАЛГАА



Захиалагч: АНУ-ын Азийн сан

Судалгааны зорилго

1. Гэр хорооллын оршин суугчдын хандлагыг тодорхойлж, тухайн мэдээллийг цаашдын үйлчилгээний төлөвлөгөөнд тусгах асуудлыг Улаанбаатар хотын захиргаатай хэлэлцэх мэдээллийн эх үүсвэр болгон ашиглах.
2. Оршин суугчдын үзэл бодолд урт хугацаанд ямар өөрчлөлт орж буйг хэмжих суурь судалгаа болгох

Зорилт:

3. Гэр хорооллын оршин суугчдын төрөөс үзүүлдэг нийтийн үйлчилгээний талаарх үзэл бодол, хандлагыг тодорхойлох
4. Гэр хороолол дахь Захирагчийн ажлын алба болон хотын захиргааны чухал санаачлагуудын талаарх иргэдэд хүрэх мэдээлэл ба иргэдийн оролцоог хянах систем үүсгэх.
5. Гэр хорооллын хөгжлийн талаарх үзэл бодлын ялгааг гэр хорооллуудын хооронд харьцуулах
6. Гэр хорооллын оршин суугчдын хувьд хамгийн чухал гэж үздэг үйлчилгээнд тулгардаг бэрхшээлүүдийг тодорхойлох.

Үндсэн мэдээлэл



Хамрах хүрээ

Судалгаа нь Улаанбаатар хотын Баянхошуу, Толгойт, Наран, Туул, Био, Өлзийт, Яармаг, Нисэх, Дэнж, Хайлааст, Чингэлтэй, Дамба, Сэлх, Бэлх, Дарь-Эх, Цайз, Шархад, Амгалан, Улиастай, Зурагт, Гандан, Дэвшил зэрэг гэр хорооллын 305 цэгээс 1525 өрхийг хамруулж байна. Мөн гэр хорооллын иргэдэд эрчим хүч, дулаан, цэвэр ус, нийтийн тээвэр, хог хаягдал, үерийн ус, эрүүл мэнд, боловсрол, онцгой байдлын зэрэг үйлчилгээ үзүүлэгч 44 байгууллагыг хамран хийгдэж байгаа юм.

Судалгааны дизайн, арга зүй:

Судалгааны мэдээллийг барим бичиг судлах, хагас стандартчилсан ярилцлага, ганцаарчилсан ярилцлага, ажиглалтын аргаар цуглуулав.



2013 ОНЫ
5 сараас

2013 ОНЫ
10 сар



1525 Өрх



28 Ганцаарчилсан
Ярилцлага



10 Фокус бүлгийн
Ярилцлага



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

ҮР ЧАДВАР БОЛОН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА



Захиалагч: ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ


Судалгааны зорилго

Зорилтот бүс нутагт мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ болон үр чадварын эрэлт хэрэгцээг тодорхойлох, ШХА-ийн мэргэжлийн боловсролыг дэмжих төсөлд хамтран ажиллах, синергийн үр нөлөө үзүүлэх, зохицуулах орон нутгийн хамтрагчийн боломжийг үнэлэх зорилготой юм. Хэрэгцээний үнэлгээ нь зөвхөн баримт бичиг боловсруулаад зогсохгүй холбогдогч талуудын хооронд үр дүнтэй зохицуулалт хийх зөвлөмжийг агуулна.

Судалгааны зорилт

- Зорилтот бүс нутгийн эдийн засгийн болон хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн нөхцөл байдал, мөн ирээдүйн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд төслийн үзүүлж болох нөлөөллийг судлах.
- Сүүлийн үед хийгдсэн хөдөлмөрийн зах зээлийн дүн шинжилгээ болон судалгаануудыг тоймлон үзэх.
- Үр чадвар болон мэргэжлийн чиг баримжаа олгох хэрэгцээ шаардлагыг ярилцлагад оролцогчдоос олж тогтоох ялангуяа хүйс, газар зүйн байршил, уламжлал болон аж үйлдвэржсэн байдал зэрэг шинж тэмдгүүдээр харьцуулан үзнэ
- Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдээс явуулж буй үр чадвар олгох сургалт болон үр чадвар олгох төсөлд хамрагдах нөөц боломж, сонирхлыг олж тогтоох
- Зорилтот орон нутгуудад бусад байгууллагуудаас явуулж буй үр чадвар олгох сургалтын давуу тал болон сул тал, нөөц боломж болон хүндрэл бэрхшээлийг олж тогтоон, үр чадварын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох.
- Одоогийн үр чадвар олгох сургалтын нөөц, бэрхшээл, давуу сул талыг үнэлэх, тодорхойлсон үр чадварын хэрэгцээ, ШХА-ын МБС-ын төсөл болон бусад холбогдох төслийн хамтын ажиллагааны боломжийг тодорхойлох;
- Одоогийн үр чадвар олгох механизмыг үнэлэх
- МБС-ын төсөл болон богино хугацааны сургалтаар эзэмшүүлэх үр чадварын талаар зөвлөгөө өгөх
- Хэрэгцээ шаардлагыг тодорхойлох гол үр дүнгүүдийг агуулсан судалгааны тайланг хүлээлгэн өгөх.

Үндсэн мэдээлэл



Хамрах хүрээ

Энэхүү судалгааны зорилтот бүлэг нь дээрх 6 аймгийн ажил олгогчид болон цөөн малтай малчид, зуданд малгүй болсон малчид, 9 ба 11 дүгээр анги төгссөн сурагчид юм.

Судалгааны дизайн, арга зүй:

Судалгааны зорилтот бүлэг тус бүрт зориулан бэлтгэсэн арга зүй, хэрэглэгдэхүүний дагуу мэдээлэл цуглуулсан. Судалгааны цаг хугацааны давчуу байдал, мэдээллийн нууцыг хадгалах шаардлага зарим нэг хязгаарлагдмал нөхцөл байдлын дор хийгдсэн.



2013 ОНЫ
2 сараас

2013 ОНЫ
4 сар



471 Насанд хүрэгчид

125 Оюутан

169 Ажил олгогч

54 Бусад оролцогч тал



6 Ганцаарчилсан Ярилцлага



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

ШВЕЙЦАРЫН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР (2013-2016)-ИЙН МОНИТОРИНГИЙН СУДАЛГАА



Захиалагч: Швейцарын Хөгжлийн Агентлаг

Хамтрагч: Ногоон Алт, Усны нэгдсэн менежмент, Монгол төмс төсөл


Судалгааны зорилго

2013 оны суурь судалгаа нь 2013-2016 онд хэрэгжих Швейцарын хамтын ажиллагааны стратегид хийгдэхээр төлөвлөгдөөд буй хяналт, үнэлгээний эхлэх цэгийг тодорхойлно.

Судалгааны зорилт

- ШХА-ын хамтын ажиллагааны түвшин дэх 6 шалгуур үзүүлэлтийг тодорхойлох
- Судалгаанд хамруулсан төслийн үр ашиг хүртэгчдийн ерөнхий онцлогийг тодорхойлох зорилготой юм.

Үндсэн мэдээлэл



Хамрах хүрээ

Хангай, Баруун, Төвийн бүсийн 8 аймаг, 22 сум
Суурь судалгаа нь ШХА-аас хэрэгжүүлж буй зорилтот бүлгүүдийг хамарч байгаа болно:

- Ногоон Алт: Завхан, Ховд, Баян-Өлгий, Увс, Баянхонгор, Архангай, Говь-Алтай
- Монгол Төмс төсөл: Завхан, Ховд, Баян-Өлгий, Увс, Баянхонгор, Архангай, Говь-Алтай (зорилтот аймгууд);
- Усны Нэгдсэн Менежмент: Ховд аймаг.

Судалгааны дизайн, арга зүй:

Асуулга. Энэхүү суурь судалгааны арга нь асуулга болно. Үр дагаврын индикаторуудыг хэмжихдээ уг асуулгаийн дийлэнх хэсэг нь хувь хүний мэдээлэлд чиглэсэн байгаа бол зарим хэсэг нь нь өрхтэй холбоотой асуултуудыг багтаасан болно.

Энэхүү асуулга нь нийгэм эдийн засгийн мэдээлэл, нэвтрүүлэх үйлчилгээний талаарх ойлголт, орлогын өөрчлөлт, хөдөө аж ахуйн усны хүртээмж, малчдын малын даац, төмс болон бусад ногооны ургацын талбай зэрэг сэдвүүдийг хамруулна.



2013 ОНЫ
5 сараас

2013 ОНЫ
11 сар



1294 Асуулга

ХЭРЭГЖИЖ БҮЙ ТӨСЛҮҮД






Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг



ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛААС ХЯНАЛТЫН ЧИГ ҮҮРГЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БОЛОН НУТГИЙН УДИРДЛАГЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗАСАГЛАЛЫН ТЭНЦВЭРИЙГ СУДЛАН САНАЛ, ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛАХ СУДАЛГАА



Хамрах хүрээ

Өмнөговь	Даланзадгад
	Баян-Овоо
Завхан	Улиастай
	Алдархаан
Дорнод	Хэрлэн
	Булган
Өвөрхангай	Арвайхээр
	Тарагт

Захиалагч: “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” төсөл
Судалгааны зорилго

Нутгийн өөрөө удирдах ба захиргааны байгууллагын засаглах үйл явц харилцан уялдаатай, тэнцвэртэй байх харилцааны онол, практикийн асуудлыг судлан санал, зөвлөмж боловсруулна.

Зорилт

1. ИТХ-аас хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж буй эрх зүйн орчинг судална.
2. Нутгийн өөрөө удирдах ба захиргааны байгууллагын засаглах үйл явцын тэнцвэрийн эрх зүйн орчин, онол практикийг судална.
3. Гадаад орны нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын талаар харьцуулсан судалгаа хийнэ.
4. Судалгааны сэдвийн чиглэлээр өмнө нь хийгдэж байсан ижил төстэй ажлын мэдээллийн сан бүрдүүлнэ.



2013 ОНЫ
10 сараас

2014 ОНЫ
3 сар



303 Иргэн




46 Ганцаарчилсан
Ярилцлага



80 ИТХ-ын
материал

БАЯНХОНГОР АЙМАГТ “ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ”-ИЙН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГАА



Хамрах хүрээ

Баянхонгор аймгийн төв, долоон сум

Судалгааны дизайн, арга зүй

Энэхүү судалгаанд тоон болон чанарын судалгааны аргыг ашиглана. Ерөнхийдөө суурь судалгаанд ашиглагдсан судалгааны аргыг ашиглах бөгөөд, энэ нь суурь болон төгсгөлийн судалгааны үр дүнг харьцуулж төслийн үр нөлөөг хэмжих боломжийг олгоно.

Захиалагч: Дэлхийн Зөн Монгол ОУБ

Хамтрагч: ЭМШУИС-ийн “Нийгмийн эрүүл мэндийн сургууль”

Судалгааны зорилго

Энэхүү үнэлгээний судалгааны зорилго нь Дэлхийн Зөнгийн “Эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах төсөлд хамрагдсан зорилтот бүлэгт гарсан төслийн үр нөлөөг хэмжих юм.

Зорилт

- Хөтөлбөрийн дизайны хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дагаврыг үнэлэх
- Дэлхийн зөнгийн төслийн үр ашиг хүртэгчдийн дундах төслөөс бий болсон нөлөөллийн ажлын үр нөлөө болон өөрчлөлтийг тодорхойлох (хүүхэд, гэр бүл, олон нийт)
- Хөтөлбөртэй холбоотой шууд болон шууд бус амжилттай туршлагаудыг тодорхойлох
- Цаашид сонгогдсон газруудад төсөл хэрэгжих боломжийг тодруулах, санал зөвлөмж гаргах




2013 ОНЫ
9 сараас



386 Хүүхэд **125** Хөхүүл эхчүүд **131** Жирэмсэн эхчүүд

“ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХАД УУЛАМЖЛАЛТ БОЛОН ШИНЖЛЭХ УХААНЫ АРГЫГ АШИГЛАХ НЬ” СУДАЛГАА



Судалгааны дизайн, арга зүй

Энэ судалгаа нь төслийн эхлэлтийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа учраас дүрслэх, хөндлөн үргэлжлэх судалгааны дазайнаар хийгдэнэ.

- Дүрслэх: Судалгаа нь оролцогч талуудын хандлага, байр суурь, үзэл бодлыг ямар байгааг бодитоор тоочин, дүрслэн гаргаж ирнэ. Ямарваа учир шалтгаант холбоо хамаарлыг тогтоохыг эрмэлзэхгүй.
- Хөндлөн үргэлжлэх: Судалгааны мэдээллийг олон тооны респондентоос үндэсний хэмжээнд нэг цаг хугацаанд цуглуулна.

Захиалагч: Мерси Кор Монгол ОУБ Судалгааны зорилго

Энэхүү судалгааны ажлаар зудын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даван туулах үндэсний тогтолцоог үнэлэх юм. Ингэхдээ зудын эрсдэлд өртөгч малчин өрхүүд, гол оролцогч талууд болох орон нутгийн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын чадавхи, одоогийн авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнтэй байдал болон цаашид үүсч байгаа хэрэгцээ шаардлагыг тогтооно.

Хамрах хүрээ

Ховд, Баян-Өлгий-Увс, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Хөвсгөл, Завхан, Баянхонгор, Говь-Алтай, Хэнтий, Сүхбаатар, Өвөрхангай, Архангай



2013 ОНЫ 10 сараас **2014** ОНЫ 3 сар



1061 Өрх



42 Ганцаарчилсан Ярилцлага



83 Баримт бичиг




Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC

Швейцарийн хөгжлийн агентлаг



“15-24 НАСНЫ ЗАЛУУЧУУДЫН БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД” ЧАНАРЫН СУДАЛГАА



Хамрах хүрээ

Энэхүү төсөл нь хүн ам төвлөрсөн 6 гол талбар болох Улаанбаатар, Дархан-Уул, Дорнод, Ховд аймгууд болон Дорнод аймгийн Баян-Уул сум, Ховд аймгийн Ховд сумдаас судалгаанд оролцогчдыг түүвэрлэж авна.

Судалгааны дизайн, арга зүй

Судалгааны бүхий л аргууд нь бэлгийн нөхөн үржихүйтэй холбоотой зан үйлүүдийг тодорхойлогч олон төрлийн хүчин зүйлүүдийн тухай гүнзгий ойлголтыг олж авахад зориулагдсан. Судалгааны мэдээлэл цуглуулах шатанд ашиглах чанарын судалгааны аргуудад зорилтот хүн амын төлөөлөлтэй хийх фокус бүлгийн ярилцлага болон орон нутгийн гол оролцогч талуудтай хийх ганцаарчилсан ярилцлагуудыг хамруулна.

Захиалагч: НҮБ-ийн Хүн Амын Сан

Хамтрагч: Карол Андервүүд, дэд профессор, Жонн Хопкинсийн Их сургууль

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Монголын залуучуудын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн хэрэгцээг хангахад чиглэсэн Зан Үйлийг Өөрчлөх Харилцааны Стратегийг боловсруулахаар зорьж буй үйл ажиллагааг дэмжих нарийвчилсан чанарын нотолгоог бий болгох юм. Төслийн хүрээнд хэрэгжиж буй чанарын судалгаа нь залуучуудын эрүүл мэндийн дадал, зан үйл болон хандлагын талаарх гүнзгийрүүлсэн суурь үнэлгээг бий болгохыг зорьсон.

- Бэлгэвчийн хэрэглээ гэх мэт орчин үеийн жирэмслэлтээс сэргийлэх аргуудын хэрэглээ, бэлгийн харилцаа гэх мэт эрүүл мэндийн зан үйлийг бий болгодог нийгэм, соёлын, хувь хүний, олон нийтийн хүчин зүйлүүдийг ойлгох
- Хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт, ХДХВ/ДОХ, БЗДХ-ын тархалтыг бууруулахад саад болж буй хувь хүний болон олон нийтийн дунд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлох
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулах зорилготой нөлөөллийн үйл ажиллагаанд ач холбогдолтой хувь нэмрийг оруулах



2013 ОНЫ
9 сараас

2014 ОНЫ
3 сар




20 Ганцаарчилсан
Ярилцлага



24 Фокус бүлгийн
Ярилцлага

УСНЫ ТАЛААРХИ ИРГЭДИЙН МЭДЛЭГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ СУУРЬ СУДАЛГАА



Захиалагч: Олон Улсын Санхүүгийн Корпораци

Судалгааны зорилго

Дэлхийн банкны салбар байгууллага болох Олон улсын санхүүгийн корпорациас хэрэгжүүлэх “Монголын уул уурхай ба ус - Тогтвортой бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн суурь мэдээллийг бий болгох үүднээс Өмнөговь аймгийн нийт 15 суманд иргэдийн усны талаархи мэдлэг хандлагыг тодорхойлох.

Уул уурхай хөгжсөн орон нутагт амьдарч буй иргэдийн усны талаархи мэдлэг, хандлага, практикийг судалж, ялангуяа уул уурхайн нөлөөллөөс усны нөөц, менежментэд гарсан эерэг болон сөрөг хандлага, санаа бодлыг тусгах явдал. Цуглуулсан мэдээлэлд үндэслэн хөтөлбөрийн хэрэгжилтэд зөвлөмж гаргасан юм.

Хамрах хүрээ

Өмнөговь аймгийн бүх сум



2013 ОНЫ
9 сараас

2014 ОНЫ
2 сар



1040 Иргэн